# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2026 оны 07 дугаар сарын 02
№25 (1420)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

# ГАРЧИГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ


| | | | |
|---|---|---|---|
| 101. | Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | | 1119 |
| 102. | Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай | | 1136 |
| 103. | Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | | 1138 |
| 104. | Хууль хүчингүй болсонд тооцох тухай | | 1139 |


## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ


| | | | |
|---|---|---|---|
| 105. | Хуулийн төсөл буцаах тухай | Дугаар 33 | 1140 |


## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ


| | | | |
|---|---|---|---|
| 106. | Ерөнхий төлөвлөгөө батлах тухай | Дугаар 73 | 1142 |
| 107. | Жагсаалт батлах тухай | Дугаар 77 | 1190 |
| 108. | Журам батлах тухай | Дугаар 79 | 1192 |

| | | | |
|---|---|---|---|
| ᠑᠐᠓᠂ | ᠡᠷᠦᠩᠬᠡᠢ ᠪᠣᠯᠪᠠᠰᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠬᠠᠤᠯᠢ | ᠳᠤᠭᠠᠷ ᠒᠘ | ᠑᠑᠘᠒ |
| ᠑᠐᠕᠂ | ᠳᠡᠭᠡᠳᠦ ᠪᠣᠯᠪᠠᠰᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠬᠠᠤᠯᠢ | ᠳᠤᠭᠠᠷ ᠕᠕ | ᠑᠑᠘᠐ |
| ᠑᠐᠖᠂ | ᠮᠡᠷᠭᠡᠵᠢᠯ ᠰᠤᠷᠭᠠᠯᠲᠠ ᠪᠣᠯᠪᠠᠰᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠬᠠᠤᠯᠢ | ᠳᠤᠭᠠᠷ ᠕᠒ | ᠑᠑᠗᠒ |
| | ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ | | |
| ᠑᠐᠔᠂ | ᠵᠠᠰᠠᠭ ᠤᠨ ᠬᠠᠭᠠᠯᠲᠠ ᠪᠣᠯᠪᠠᠰᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠬᠠᠤᠯᠢ | ᠳᠤᠭᠠᠷ ᠒᠒ | ᠑᠑᠗᠐ |
| | ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ | | |
| ᠑᠐᠗᠂ | ᠵᠠᠰᠠᠭ ᠪᠦᠷᠢᠨ ᠡᠷᠬᠡ ᠪᠦᠬᠦᠢ ᠪᠠᠷ ᠲᠥᠯᠦᠪᠯᠡᠬᠦ ᠬᠠᠤᠯᠢ | | ᠑᠑᠒᠘ |
| ᠑᠐᠒᠂ | ᠶᠡᠷᠦᠩᠬᠡᠶᠢᠯᠡᠭᠴᠢ ᠶᠢᠨ ᠵᠠᠷᠯᠢᠭ ᠬᠠᠤᠯᠢ<br>ᠲᠥᠰᠦᠪ ᠤᠨ ᠲᠥᠰᠦᠪᠯᠡᠯᠲᠡ ᠪᠠᠶᠢᠳᠠᠯ ᠤᠨ ᠬᠠᠤᠯᠢ ᠵᠠᠰᠠᠭ ᠪᠠᠷ | | ᠑᠑᠒᠔ |
| ᠑᠐᠘᠂ | ᠲᠥᠰᠦᠪ ᠤᠨ ᠲᠥᠰᠦᠪᠯᠡᠯᠲᠡ ᠶᠢᠨ ᠬᠠᠤᠯᠢ<br>ᠲᠥᠰᠦᠪ ᠤᠨ ᠪᠠᠢᠳᠠᠯ ᠪᠠ ᠴᠢᠭᠯᠡᠯ᠂ ᠒᠐᠒᠔ — ᠒᠐᠒᠘ ᠣᠨ ᠤ<br>ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠡᠳ᠋ᠢᠶᠡᠨ ᠵᠠᠰᠠᠭ ᠤᠨ ᠲᠥᠰᠦᠪ ᠤᠨ ᠒᠐᠒᠕ ᠣᠨ ᠤ | | ᠑᠑᠒᠖ |
| ᠑᠐᠑᠂ | ᠶᠡᠷᠦᠩᠬᠡᠶᠢᠯᠡᠭᠴᠢ ᠶᠢᠨ ᠵᠠᠷᠯᠢᠭ ᠬᠠᠤᠯᠢ<br>ᠶᠡᠷᠦᠩᠬᠡᠢ ᠪᠠ ᠬᠠᠤᠯᠢ ᠵᠠᠰᠠᠭ ᠪᠠᠷ ᠳᠦᠷᠢᠮ᠂<br>ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠬᠤ ᠶᠠᠪᠤᠳᠠᠯ ᠪᠠᠷ ᠳᠡᠮᠵᠢᠯᠡᠬᠦ ᠪᠠᠶᠢᠳᠠᠯ ᠤᠨ | | ᠑᠑᠑᠘ |
| | ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠵᠠᠰᠠᠭ | | |

ᠬᠠᠪᠰᠤᠷᠤᠯᠲᠠ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 05 дугаар сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

## БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

**1/3 дугаар зүйлийн 3.1.12, 3.1.13 дахь заалт:**

“3.1.12.“байгаль орчны төлөв байдлын тодорхойлолт" гэж энэ хуулийн 7.9.3-т заасан зэрэглэлд хамаарах төслийг хэрэгжүүлж эхлэхээс өмнөх төслийн байршлын байгалийн нөхцөл, орчны онцлогийг тогтоохыг;

3.1.13.“байгаль орчны нөлөөллийн үнэлгээний нэмэлт тодотгол” гэж төслийн хүчин чадал, технологи, байршил, талбайн хэмжээ өөрчлөгдсөн, хуулиар тогтоосон хугацаа дуусгавар болсон тохиолдолд байгаль орчны нөлөөллийн үнэлгээг шинэчлэхийг.”

**2/4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсэг:**

“4.4.Мэргэжлийн зөвлөлийн ажиллах журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

**3/6 дугаар зүйлийн 6.7-6.9 дэх хэсэг:**

“6.7.Байгаль орчны төлөв байдлын тодорхойлолтыг төсөл хэрэгжүүлэгч хариуцан гүйцэтгэх бөгөөд үнэлгээг Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 14 дэх заалтад заасан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэдээллийн санд бүртгүүлнэ.

6.8.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний үр дүн, нөлөөлөл бууруулах арга хэмжээг тухайн бүс нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа төсөл хэрэгжүүлэгчийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ болон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгуулж, хэрэгжилтийг хянах үүрэгтэй.

6.9.Аймаг, нийслэлийн Засаг дарга нь тодорхой бүс нутаг, сав газарт хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийлгэх хүсэлтийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана.”

**4/7 дугаар зүйлийн 7.8-7.15 дахь хэсэг:**

“7.8.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

7.9.Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, цар хүрээ, төсөл хэрэгжих газар нутгийн байршил, хүчин чадлыг харгалзан төслийг дараах байдлаар ангилна:

7.9.1.зэрэглэл I буюу их эрсдэлтэй төсөл гэж байгаль орчин, нийгмийн бүрэлдэхүүн хэсэгт үзүүлэх сөрөг болон хуримтлагдах нөлөөлөл нь төслийн нөлөөллийн бүсийн хэмжээгээр хязгаарлагдахгүй, байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөллийг бууруулахад нэмэлт арга хэмжээ шаардлагатай, газар чөлөөлөлтийн хамрах хүрээ ихтэй үйл ажиллагааг;

7.9.2.зэрэглэл II буюу дунд эрсдэлтэй төсөл гэж байгаль орчин, нийгмийн бүрэлдэхүүн хэсэгт үзүүлэх сөрөг нөлөөлөл нь төслийн нөлөөллийн бүсийн хэмжээгээр хязгаарлагдах боломжтой, байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөллийг бууруулахад нөхцөл, болзолтой арга хэмжээ шаардлагатай, газар чөлөөлөлтийн хамрах хүрээ хязгаарлагдмал үйл ажиллагааг;

7.9.3.зэрэглэл III буюу бага эрсдэлтэй төсөл гэж байгаль орчин, нийгмийн бүрэлдэхүүн хэсэгт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл нь хязгаарлагдмал, эсхүл эрсдэлгүй үйл ажиллагааг.

7.10.Зэрэглэл I төсөлд 5 жил, зэрэглэл II төсөлд 10 жил тутамд байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд нэмэлт тодотгол хийх бөгөөд зэрэглэл III төсөлд энэ хуулийн 7.11-д заасан нөхцөл үүсээгүй тохиолдолд байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд нэмэлт тодотгол хийлгэхийг шаардахгүй.

7.11.Төслийн хүчин чадал, талбайн хэмжээ өөрчлөгдсөн тохиолдолд энэ хуулийн 7.10-т заасан хугацааг харгалзахгүйгээр байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд нэмэлт тодотгол хийлгэх бөгөөд төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүсэлт гаргана.

7.12.Энэ хуулийн 7.7-д заасны дагуу баталсан нөлөөллийн үнэлгээ хийх төслийн ангилалд заагаагүй төсөлд байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэхийг шаардахгүй.

7.13.Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчны ерөнхий үнэлгээнд санал авах хүсэлтийг төслийн товч танилцуулга, газрын эрхтэй холбоотой баримт бичгийн хамт тухайн сум, дүүргийн Засаг даргад гаргана.

7.14.Сум, дүүргийн Засаг дарга нь төсөл хэрэгжүүлэгчээс ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч, ажлын 15 өдөрт багтаан хариу өгөх бөгөөд энэ хугацаанд шийдвэрлээгүй бол зөвшөөрсөнд тооцно.

7.15.Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 7.13-т зааснаас бусад баримт бичиг шаардахгүй."

**5/8 дугаар зүйлийн 8.4.10 дахь заалт:**

"8.4.10.энэ хуулийн 8.4.8-д заасан танилцуулгын үнэн зөвийг төсөл хэрэгжүүлэгч, тухайн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийсэн мэргэжлийн эрх бүхий байгууллага хариуцна."

**6/8 дугаар зүйлийн 8.9-8.11 дэх хэсэг:**

"8.9.Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх шаардлагатай байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх төслийг энэ хуулийн 7.7-д заасны дагуу баталсан нөлөөллийн үнэлгээ хийх төслийн ангиллаар зохицуулна.

8.10.Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр зааснаас бусад төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайланд үнэлгээний шинжилгээ хийсэн шинжээчийн дүгнэлтийг үндэслэн төслийг хэрэгжүүлэх эсэх асуудлыг ерөнхий шинжээч ажлын 10 өдөрт багтаан шийдвэрлэнэ.

8.11.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн хэрэгжилтэд Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн $10^1$ дүгээр зүйлд заасны дагуу байгаль орчны аудитыг хийлгэнэ."

**7/10 дугаар зүйлийн 10.7 дахь хэсэг:**

"10.7.Шинжээч нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг цахим хэлбэрээр хүлээн авч, холбогдох шинжилгээг хийнэ."

**8/14 дүгээр зүйлийн 14.1.4, 14.1.5 дахь заалт:**

“14.1.4.иргэний хүсэлтийн дагуу тухайн төслийн үйл ажиллагаатай холбоотой газрын хэвлийн баялгийн ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлтийн явц, үр дүнгийн талаар мэдээлэл өгөх, эсхүл танилцах боломжоор хангах;

14.1.5.хуримтлагдах нөлөөллийн үнэлгээнээс гарсан үр дүн, нөлөөлөл бууруулах арга хэмжээг тухайн төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, түүний нэмэлт тодотгол болон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтийг хангана.”

**9/17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэг:**

“17.2.Олон улсын банк, санхүүгийн байгууллагын байгаль орчин, нийгмийн нөлөөллийн бодлого, журмын хүрээнд хийж гүйцэтгэсэн байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайлан нь энэ хуулийн 7.1, 7.2, 7.3, 8.2, 8.4, 10.1, 10.5-д заасан шаардлагыг хангасан бол байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүлээн авч, энэ хуулийн 7.4-т заасан дүгнэлт, 10.4-т заасан шийдвэрийг гаргаж болно.”

**10/18 дугаар зүйлийн 18.6, 18.7 дахь хэсэг:**

“18.6.Засаг дарга энэ хуулийн 18.5-д заасан иргэний хүсэлтийн дагуу холбогдох мэдээллийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 15.6-д заасан хугацаанд гаргаж өгөх үүрэгтэй.

18.7.Иргэн тухайн төслийн үйл ажиллагаатай холбогдуулан газрын хэвлийн баялгийн ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлтийн талаарх мэдээлэл авах, танилцах хүсэлтийг төсөл хэрэгжүүлэгчид гаргаж болно.”

**2 дугаар зүйл.**Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь заалтын “төслүүдээс” гэсний дараа “байгаль орчин,” гэж, 8 дугаар зүйлийн 8.4.6 дахь заалтын “үзүүлэлтүүд,” гэсний дараа “биологийн олон янз байдлыг” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “стратегийн” гэсний дараа “болон хуримтлагдах нөлөөллийн” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалт:**

“3.1.4.“байгаль орчны төлөв байдлын үнэлгээ” гэж зэрэглэл I, II-т хамаарах төслийн техник, эдийн засгийн төлөвлөлтийн баримт бичиг, зураг төсөл, улсын болон бүс нутаг, салбарын хэмжээнд хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах явцад тэдгээрийг хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн байгаль орчин, нийгмийн төлөв байдлыг судлан тогтоож цаашид төсөл, хөтөлбөр, төлөвлөгөө, бодлого боловсруулахад анхаарах байгалийн нөхцөл, орчны онцлогийг тодорхойлохыг;”

**2/3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалт:**

“3.1.6.“байгаль орчны нөлөөллийн үнэлгээ” гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас тодорхой төслийг хэрэгжүүлэх явцад төслийн нөлөөлөлд өртөх бүсийн байгаль орчин, нийгэмд учруулж болзошгүй нөлөөлөл, цар хүрээ, үр дагаврыг төслийн үе шатуудад урьдчилан тодорхойлж, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ тогтоохыг;”

**3/5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг:**

“5.1.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан дунд болон урт хугацааны хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах явцад хийсэн стратегийн үнэлгээний тайланг бодлогын баримт бичгийн төслийн хамт Засгийн газарт хэлэлцүүлэхээс өмнө байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.”

**4/7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг:**

“7.3.Хуульд өөрөөр заагаагүй бол төсөл хэрэгжүүлэгч нь эрх бүхий байгууллагаар баталгаажсан техник, эдийн засгийн үндэслэл, эскиз зураг, бизнес төлөвлөгөө, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, эсхүл төлөв байдлын тодорхойлолт, тухайн хамгаалалтын захиргааны болон сум, дүүргийн Засаг даргын санал, холбогдох бусад баримт бичгийг бүрдүүлж энэ хуулийн 7.7-д заасны дагуу баталсан ангиллын дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаар байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлгэнэ.”

**5/7 дугаар зүйлийн 7.6, 7.7 дахь хэсэг:**

“7.6.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайланд үнэлгээний шинжилгээ хийж, дүгнэлт гаргах ерөнхий шинжээч, шинжээчийн эрхийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгох бөгөөд дараах шаардлагыг хангасан байна:

7.6.1.ерөнхий шинжээч нь байгаль орчны чиглэлээр 8-аас доошгүй жил ажилласан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх мэргэжлийн чадвар, ажлын туршлагатай байх;

7.6.2.шинжээч нь байгаль орчны чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх мэргэжлийн чадвар, ажлын туршлагатай байх.

7.7.Нөлөөллийн үнэлгээний журам, үнэлгээ хийх төслийн ангиллыг Засгийн газар батлах бөгөөд уг журам, ангилалд байгаль орчны нөлөөллийн үнэлгээтэй холбоотой асуудал, үнэлгээний шинжилгээний арга, хянан магадлагаа, олон нийтийн оролцоо, ерөнхий үнэлгээ хийх харьяалал, биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах, байгаль орчны нөлөөллийн үнэлгээний нэмэлт тодотгол, нийгмийн нөлөөллийн болон эрүүл мэндийн үнэлгээтэй холбогдсон зохицуулалтыг тусгана.”

**6/8 дугаар зүйлийн 8.4.8 дахь заалт:**

“8.4.8.энэ хуулийн 10.5-д заасны дагуу төслийн нөлөөлөлд өртөх иргэдийн саналыг тусгасан байдал, танилцуулга;”

**7/8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэг:**

“8.7.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийсэн аж ахуйн нэгж нь судалгааны анхдагч материал, үнэлгээний мэргэжилтний судалгааны ажлын дүнг эх хувиар нь хадгалах бөгөөд нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 14 дэх заалтад заасан мэдээллийн санд цахим хэлбэрээр хадгална.”

**8/9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг:**

“9.2.Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг энэ хуулийн 7.9-д заасан ангиллаас хамааран 10 хүртэлх жилийн хугацаагаар батлах бөгөөд уг төлөвлөгөө нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг байна.”

**9/9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэг:**

“9.4.Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах, хянах, тайлагнах журам, аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

**10/9 дүгээр зүйлийн 9.6 дахь хэсэг:**

“9.6.Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоогдсон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, нөхөн сэргээлт болон дүйцүүлэн хамгаалал хийх, хүлэмжийн хийг бууруулах талаар төрөөс авч хэрэгжүүлж байгаа бодлого, арга хэмжээ болон тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгана.”

**11/10 дугаар зүйлийн 10.4, 10.5 дахь хэсэг:**

“10.4.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Байгаль орчныг хамгаалах тухай, Усны тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан шаардлага, энэ хуулийн 10.5-д заасан танилцуулгаас гарсан саналыг тусгасан байдал, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд үнэлгээний шинжилгээ хийсэн шинжээч, мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн төслийг хэрэгжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

10.5.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага хамтран төслийн нөлөөлөлд өртөх иргэдэд танилцуулж, санал авах бөгөөд баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын даргад хүсэлт илгээснээс хойш 30 хоногийн дотор уг асуудлаар хурал хуралдсан тохиолдолд тайланг танилцуулж, санал авах ажлыг зохион байгуулна.”

**12/14 дүгээр зүйлийн 14.1.2 дахь заалт:**

“14.1.2.байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх иргэд, холбогдох төрийн захиргааны төв байгууллагад тогтоосон хугацаанд мэдээлж, тайлагнах;”

**13/18 дугаар зүйлийн 18.4, 18.5 дахь хэсэг:**

“18.4.Тухайн төслийн нөлөөлөлд өртөх иргэдэд танилцуулах, санал авах шаардлагатай байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийгдэх төслийг энэ хуулийн 7.7-д заасны дагуу баталсан нөлөөллийн үнэлгээ хийх төслийн ангиллаар батална.

18.5.Тухайн нутаг дэвсгэрт хэрэгжиж байгаа төслүүдийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээ нь байгаль орчны нөлөөллийн үнэлгээний мэдээллийн санд олон нийтэд нээлттэй байрших бөгөөд иргэн газрын хэвлийн баялгийн ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлт болон төрийн эрх бүхий байгууллагаас хяналтын чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар нэмэлт мэдээлэл авах хүсэлтийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад гаргах эрхтэй.”

**4 дүгээр зүйл.**Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.15 дахь хэсгийн “байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэснийг “байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэж, 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “18 өдөрт” гэснийг “15 өдөрт” гэж, мөн зүйлийн 10.3 дахь хэсгийн “18 хүртэл” гэснийг “15 хүртэл” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.**Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн хавсралтаар баталсан Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийх төслийн ангиллыг бүхэлд нь хүчингүй болсонд тооцсугай.

**6 дугаар зүйл.**Энэ хуулийг 2026 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА С.БЯМБАЦОГТ**

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠠᠤᠯᠢ

᠒᠐᠒᠖ ᠣᠨ ᠤ ᠐᠑ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠒᠒ - ᠨ ᠡᠳᠦᠷ ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠬᠣᠲᠠ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠢᠷᠭᠡᠨ ᠦ
ᠪᠦᠷᠢᠳᠬᠡᠯ ᠦᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠳᠤ
ᠨᠡᠮᠡᠯᠲᠡ᠂ ᠥᠭᠡᠷᠡᠴᠢᠯᠡᠯᠲᠡ ᠣᠷᠤᠭᠤᠯᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ

᠑ ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ᠄ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠢᠷᠭᠡᠨ ᠦ ᠪᠦᠷᠢᠳᠬᠡᠯ ᠦᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠳᠤ ᠳᠣᠣᠷᠠᠬᠢ ᠠᠭᠤᠯᠭ᠎ᠠ ᠲᠠᠢ ᠬᠡᠰᠡᠭ᠂ ᠵᠦᠢᠯ ᠨᠡᠮᠡᠭᠰᠡᠭᠡᠢ᠄

᠓/᠑ ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠓᠂᠑᠂᠑᠓᠂ ᠓᠂᠑᠂᠑᠔ ᠳᠡᠬᠢ ᠵᠠᠭᠠᠯᠲᠠ᠄

«᠓᠂᠑᠂᠑᠓᠂ «ᠢᠷᠭᠡᠨ ᠦ ᠪᠦᠷᠢᠳᠬᠡᠯ ᠦᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠦᠨ ᠨᠢᠭᠡᠳᠦᠭᠰᠡᠨ ᠰᠠᠩ» ᠭᠡᠳᠡᠭ ᠨᠢ ᠢᠷᠭᠡᠨ ᠦ ᠪᠦᠷᠢᠳᠬᠡᠯ ᠦᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠢ ᠬᠠᠳᠠᠭᠠᠯᠠᠬᠤ᠂ ᠪᠣᠯᠪᠠᠰᠤᠷᠠᠩᠭᠤᠢ ᠪᠣᠯᠭᠠᠬᠤ ᠫᠷᠣᠭ᠌ᠷᠠᠮ ᠬᠠᠩᠭᠠᠮᠵᠢ ᠶᠢᠨ ᠴᠣᠭᠴᠠ ᠶᠢ ᠬᠡᠯᠡᠨ᠎ᠡ ᠃

«᠓᠂᠑᠂᠑᠔᠂ «ᠢᠷᠭᠡᠨ ᠦ ᠪᠦᠷᠢᠳᠬᠡᠯ ᠦᠨ ᠭᠡᠷᠡᠴᠢᠯᠡᠭᠡ» ᠭᠡᠳᠡᠭ ᠨᠢ ᠡᠨᠡ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠖᠂᠘᠂᠔ - ᠳᠦ ᠵᠠᠭᠠᠰᠠᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠢ ᠢᠷᠭᠡᠨ ᠦ ᠪᠦᠷᠢᠳᠬᠡᠯ ᠦᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠳᠤ ᠪᠦᠷᠢᠳᠬᠡᠭᠰᠡᠨ ᠢ ᠨᠣᠲᠠᠯᠭᠠᠵᠢᠭᠤᠯᠤᠭᠰᠠᠨ ᠪᠢᠴᠢᠭ ᠪᠠᠷᠢᠮᠲᠠ ᠶᠢ ᠬᠡᠯᠡᠨ᠎ᠡ ᠃»

᠔/᠑ ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠔᠂᠔ ᠳᠡᠬᠢ ᠬᠡᠰᠡᠭ᠄

«᠔᠂᠔᠂ ᠢᠷᠭᠡᠨ ᠦ ᠪᠦᠷᠢᠳᠬᠡᠯ ᠦᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠢ ᠲᠥᠷᠦ ᠶᠢᠨ ᠨᠢᠭᠡᠳᠦᠭᠰᠡᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠦᠨ ᠰᠢᠰᠲ᠋ᠧᠮ ᠳᠦ ᠨᠢᠭᠡᠳᠦᠭᠰᠡᠨ ᠪᠠᠢᠳᠠᠯ ᠲᠠᠢ ᠬᠥᠲᠦᠯᠦᠨ᠎ᠡ ᠃»

᠔/᠔ ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠔᠂᠙ - ᠔᠂᠑᠐ ᠳᠡᠬᠢ ᠬᠡᠰᠡᠭ᠄

«᠔᠂᠙᠂ ᠢᠷᠭᠡᠨ ᠦ ᠪᠦᠷᠢᠳᠬᠡᠯ ᠦᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠦᠨ ᠨᠢᠭᠡᠳᠦᠭᠰᠡᠨ ᠰᠠᠩ ᠢ ᠪᠦᠷᠢᠳᠬᠡᠯ ᠦᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠡᠷᠬᠢᠯᠡᠨ ᠡᠬᠢᠯᠡᠭᠦᠯᠦᠨ ᠠᠵᠢᠯᠯᠠᠭᠤᠯᠤᠨ᠎ᠠ᠂ ᠢᠷᠭᠡᠨ ᠦ ᠪᠦᠷᠢᠳᠬᠡᠯ ᠦᠨ ᠭᠡᠷᠡᠴᠢᠯᠡᠭᠡ ᠶᠢ ᠡᠨᠡ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠔ ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠑᠐ ᠳᠡᠬᠢ ᠬᠡᠰᠡᠭ ᠲᠦ ᠵᠠᠭᠠᠰᠠᠨ ᠢᠷᠭᠡᠨ ᠦ ᠪᠦᠷᠢᠳᠬᠡᠯ ᠦᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠦᠨ ᠰᠠᠩ ᠳᠤ ᠬᠠᠳᠠᠭᠠᠯᠠᠨ᠎ᠠ ᠃»

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

«᠖.᠒.ᠪᠠᠩᠬᠢᠨ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠬᠠᠷᠢᠯᠴᠠᠭᠴᠢ ᠳᠤ ᠲᠣᠬᠢᠷᠠᠭᠤᠯᠤᠯᠲᠠ ᠬᠢᠬᠦ᠂ ᠪᠠᠩᠬᠢᠨ ᠬᠠᠷᠢᠯᠴᠠᠭᠴᠢ ᠶᠢᠨ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠬᠠᠷᠢᠯᠴᠠᠭᠴᠢ ᠳᠤ ᠲᠣᠬᠢᠷᠠᠭᠤᠯᠤᠯᠲᠠ ᠬᠢᠬᠦ᠂ ᠰᠠᠩᠬᠦᠦ ᠶᠢᠨ ᠪᠠᠩᠬᠢᠨ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠠᠯᠪᠠᠨ ᠲᠤᠰᠢᠶᠠᠯ ᠤᠨ ᠡᠷᠬᠡ ᠢ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠦᠨ᠎ᠡ᠄»

᠖/᠐᠖ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠒.᠖ ᠳᠠᠬᠢ ᠬᠡᠰᠡᠭ᠄

«᠖.᠙.ᠪᠠᠩᠬᠢᠨ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠬᠠᠷᠢᠯᠴᠠᠭᠴᠢ ᠳᠤ ᠪᠠᠩᠬᠢᠨ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠬᠠᠷᠢᠯᠴᠠᠭᠴᠢ ᠶᠢᠨ ᠠᠯᠪᠠᠨ ᠲᠤᠰᠢᠶᠠᠯ ᠢ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ᠂ ᠡᠷᠬᠡ ᠦᠭᠡᠢ᠂ ᠡᠷᠬᠡ ᠦᠭᠡᠢ ᠪᠠᠢᠬᠤ ᠢ ᠬᠣᠷᠢᠭᠯᠠᠨ᠎ᠠ᠄»

᠐᠙/᠙᠖ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠖.᠐᠖.᠒᠐᠒ ᠳᠠᠬᠢ ᠬᠡᠰᠡᠭ᠄

«᠖.᠒.᠐᠖.ᠪᠠᠩᠬᠢᠨ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠬᠠᠷᠢᠯᠴᠠᠭᠴᠢ ᠶᠢᠨ ᠰᠠᠩᠬᠦᠦ ᠶᠢᠨ ᠠᠯᠪᠠᠨ ᠲᠤᠰᠢᠶᠠᠯ ᠤᠨ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠬᠠᠷᠢᠯᠴᠠᠭᠴᠢ ᠳᠤ ᠪᠠᠩᠬᠢᠨ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ᠂ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠨ ᠪᠠᠩᠬᠢ᠂ ᠒᠐᠒᠖ — ᠳᠤ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠬᠠᠷᠢᠯᠴᠠᠭᠴᠢ ᠶᠢᠨ ᠰᠠᠩᠬᠦᠦ ᠶᠢᠨ ᠲᠣᠬᠢᠷᠠᠭᠤᠯᠤᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠪᠠᠩᠬᠢᠨ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠠᠯᠪᠠᠨ ᠲᠤᠰᠢᠶᠠᠯ᠂ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠬᠠᠷᠢᠯᠴᠠᠭᠴᠢ ᠶᠢᠨ ᠰᠠᠩᠬᠦᠦ ᠶᠢᠨ ᠪᠠᠩᠬᠢᠨ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠠᠯᠪᠠᠨ ᠲᠤᠰᠢᠶᠠᠯ ᠢ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠦᠨ᠎ᠡ᠄»

«᠖.᠒.᠐᠖.ᠪᠠᠩᠬᠢᠨ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠬᠠᠷᠢᠯᠴᠠᠭᠴᠢ ᠶᠢᠨ ᠰᠠᠩᠬᠦᠦ ᠶᠢᠨ ᠲᠣᠬᠢᠷᠠᠭᠤᠯᠤᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠬᠠᠷᠢᠯᠴᠠᠭᠴᠢ᠂ ᠪᠠᠩᠬᠢᠨ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠠᠯᠪᠠᠨ ᠲᠤᠰᠢᠶᠠᠯ ᠤᠨ ᠡᠷᠬᠡ ᠢ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ᠂ ᠪᠠᠩᠬᠢᠨ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠬᠠᠷᠢᠯᠴᠠᠭᠴᠢ ᠳᠤ ᠲᠣᠬᠢᠷᠠᠭᠤᠯᠤᠯᠲᠠ ᠬᠢᠬᠦ᠂ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠨ ᠪᠠᠩᠬᠢ ᠶᠢᠨ ᠡᠷᠬᠡ ᠢ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠦᠨ᠎ᠡ᠄»

᠐᠖/᠒᠖ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠖.᠐᠖.᠒ ᠳᠠᠬᠢ ᠬᠡᠰᠡᠭ᠄

«᠖.᠒.᠐᠖.ᠪᠠᠩᠬᠢᠨ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠬᠠᠷᠢᠯᠴᠠᠭᠴᠢ ᠳᠤ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠨ ᠪᠠᠩᠬᠢ ᠶᠢᠨ ᠲᠣᠬᠢᠷᠠᠭᠤᠯᠤᠯᠲᠠ ᠬᠢᠬᠦ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠨ ᠪᠠᠩᠬᠢ᠂ ᠪᠠᠩᠬᠢᠨ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠬᠠᠷᠢᠯᠴᠠᠭᠴᠢ ᠶᠢᠨ ᠰᠠᠩᠬᠦᠦ ᠶᠢᠨ ᠠᠯᠪᠠᠨ ᠲᠤᠰᠢᠶᠠᠯ ᠢ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠦᠨ᠎ᠡ᠄»

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 05 дугаар сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

## МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2027 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2028-2029 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтийг доор дурдсанаар баталсугай:

| Д/д | Эдийн засгийн үндсэн үзүүлэлт | Төсвийн хүрээний мэдэгдэл | Төсвийн төсөөлөл | |
|---|---|---|---|---|
| | | 2027 он | 2028 он | 2029 он |
| 1 | Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/ | 5.8 | 6.0 | 6.3 |
| 2 | Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин | 7.0 | 6.0 | 5.0 |
| 3 | Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ /тэрбум төгрөг/ | 34,780.0 | 37,371.8 | 39,737.5 |
| | - Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь | 30.4 | 29.4 | 28.1 |
| 4 | Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/ | 36,493.4 | 38,644.0 | 40,444.7 |
| | - Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь | 31.9 | 30.4 | 28.6 |
| 5 | Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/ | -1,713.4 | -1,272.2 | -707.2 |
| | - Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь | -1.5 | -1.0 | -0.5 |
| 6 | Нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/ | 32,495.4 | 34,827.4 | 36,908.5 |
| | - Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь | 28.4 | 27.4 | 26.1 |
| 7 | Нэгдсэн төсвийн суурь тэнцэл /тэрбум төгрөг/ | 2,284.6 | 2,544.4 | 2,828.9 |
| | - Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь | 2.0 | 2.0 | 2.0 |
| 8 | Засгийн газрын өрийн нийт хэмжээ /тэрбум төгрөг/ | 57,114.9 | 63,610.1 | 63,651.0 |
| | - Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь | 50.0 | 50.0 | 45.0 |
| 9 | Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс хуваарилах зардлын дээд хэмжээ /тэрбум төгрөг/ | 2,823.0 | 2,998.2 | 3,173.0 |
| | - Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь | 2.5 | 2.4 | 2.2 |

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.БЯМБАЦОГТ**

[illegible]

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 06 дугаар сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

## ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсгийн “мэдэгдэл, түүний нэмэлт, өөрчлөлтийг” гэснийг “мэдэгдлийг” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсгийн “төсөл, төсвийн тодотголын” гэснийг хассугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА** **С.БЯМБАЦОГТ**

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠠᠤᠯᠢ

ᠬᠣᠶᠠᠷ ᠮᠢᠩᠭ᠎ᠠ ᠬᠣᠷᠢᠨ ᠵᠢᠷᠭᠤᠭ᠎ᠠ ᠣᠨ ᠤ ᠐᠖ ᠳᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠐᠕ ᠤ ᠡᠳᠦᠷ ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠬᠣᠲᠠ

ᠲᠥᠰᠥᠪ ᠦᠨ ᠲᠣᠭᠲᠠᠪᠤᠷᠢᠲᠠᠢ ᠪᠠᠶᠢᠳᠠᠯ ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠳᠤ ᠥᠭᠡᠷᠡᠴᠢᠯᠡᠯᠲᠡ ᠣᠷᠤᠭᠤᠯᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ

᠑ ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ᠃ ᠲᠥᠰᠥᠪ ᠦᠨ ᠲᠣᠭᠲᠠᠪᠤᠷᠢᠲᠠᠢ ᠪᠠᠶᠢᠳᠠᠯ ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠗ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠗.᠕ ᠳᠠᠬᠢ ᠬᠡᠰᠡᠭ ᠦᠨ «ᠮᠡᠳᠡᠭᠳᠡᠯ᠂ ᠲᠡᠭᠦᠨ ᠦ ᠨᠡᠮᠡᠯᠲᠡ᠂ ᠥᠭᠡᠷᠡᠴᠢᠯᠡᠯᠲᠡ ᠶᠢ» ᠭᠡᠭᠰᠡᠨ ᠢ «ᠮᠡᠳᠡᠭᠳᠡᠯ ᠢ» ᠭᠡᠵᠦ ᠥᠭᠡᠷᠡᠴᠢᠯᠡᠰᠦᠭᠡᠢ᠃

᠒ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ᠃ ᠲᠥᠰᠥᠪ ᠦᠨ ᠲᠣᠭᠲᠠᠪᠤᠷᠢᠲᠠᠢ ᠪᠠᠶᠢᠳᠠᠯ ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠗ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠗.᠕ ᠳᠠᠬᠢ ᠬᠡᠰᠡᠭ ᠦᠨ «ᠲᠥᠰᠥᠯ᠂ ᠲᠥᠰᠥᠪ ᠦᠨ ᠨᠠᠷᠢᠯᠢᠭᠤᠯᠤᠯᠲᠠ ᠶᠢᠨ» ᠭᠡᠭᠰᠡᠨ ᠢ ᠬᠠᠰᠤᠭᠠᠢ᠃

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ ᠰ.ᠪᠢᠮᠪᠠᠴᠣᠭᠲᠤ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 06 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

## ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА** **С.БЯМБАЦОГТ**

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠠᠤᠯᠢ

᠒᠐᠒᠖ ᠣᠨ ᠤ ᠐᠖ ᠳᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠐᠕ ᠤ ᠡᠳᠦᠷ ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠬᠣᠲᠠ

ᠬᠠᠤᠯᠢ ᠬᠦᠴᠦᠨ ᠦᠭᠡᠢ ᠪᠣᠯᠤᠭᠰᠠᠨ ᠳᠤ ᠲᠣᠭᠠᠴᠠᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ

ᠨᠢᠭᠡᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ᠃ ᠒᠐᠒᠕ ᠣᠨ ᠤ ᠑᠑ ᠳᠦᠭᠡᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠑᠔ ᠦ ᠡᠳᠦᠷ ᠪᠠᠲᠤᠯᠠᠭᠰᠠᠨ ᠨᠡᠮᠡᠭᠳᠡᠭᠰᠡᠨ ᠥᠷᠲᠡᠭ ᠦᠨ ᠠᠯᠪᠠᠨ ᠲᠠᠲᠠᠪᠤᠷᠢ ᠶᠢᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠳᠤ ᠨᠡᠮᠡᠯᠲᠡ᠂ ᠥᠭᠡᠷᠡᠴᠢᠯᠡᠯᠲᠡ ᠣᠷᠤᠭᠤᠯᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢ ᠬᠦᠴᠦᠨ ᠦᠭᠡᠢ ᠪᠣᠯᠤᠭᠰᠠᠨ ᠳᠤ ᠲᠣᠭᠠᠴᠠᠭᠤᠯᠤᠭᠰᠤᠭᠠᠢ᠃

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ ᠰ᠂ ᠪᠢᠮᠪᠠᠴᠣᠭᠲᠤ

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 06 дугаар сарын 11-ний өдөр | Дугаар 33 | Улаанбаатар хот

## Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.14 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 06 дугаар сарын 04-ний өдөр Монгол Улсын Их Хуралд Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг нэгдсэн хуралдааны санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.БЯМБАЦОГТ**

# ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ

᠒᠐᠒᠖ ᠣᠨ ᠤ ᠖ ᠳᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠑᠘ — ᠤ ᠡᠳᠦᠷ　　ᠳᠤᠭᠠᠷ ᠒᠒　　ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠬᠣᠲᠠ

ᠬᠠᠭᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠲᠥᠰᠥᠯ ᠢ ᠪᠤᠴᠠᠭᠠᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠴᠢᠭᠤᠯᠭᠠᠨ ᠤ ᠬᠤᠷᠠᠯᠳᠤᠭᠠᠨ ᠤ ᠳᠡᠭ ᠦᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠭᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠒᠒ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠒᠒.᠑ ᠳᠡᠬᠢ ᠬᠡᠰᠡᠭ ᠢ ᠦᠨᠳᠦᠰᠦᠯᠡᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠡᠴᠡ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠬᠤ ᠨᠢ:

᠑.ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠵᠠᠰᠠᠭ ᠤᠨ ᠭᠠᠵᠠᠷ ᠠᠴᠠ ᠒᠐᠒᠖ ᠣᠨ ᠤ ᠕ ᠳᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠑᠕ — ᠤ ᠡᠳᠦᠷ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠳᠤ [illegible]

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ　　ᠳᠠ᠂ᠠᠮᠤᠷᠵᠠᠷᠭᠠᠯ

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2026 оны 03 дугаар сарын 11-ний өдөр | Дугаар 73 | Улаанбаатар хот

**Ерөнхий төлөвлөгөө батлах тухай**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, Олон улсын гэрээний тухай хуулийн 24.3 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2003 оны 41 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийн 3.1.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн зөвлөлийн ирүүлсэн зөвлөмжүүдийг 2026-2030 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө”-г хавсралт ёсоор баталсугай.

2.Ерөнхий төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг иргэний нийгмийн байгууллагын төлөөллийн оролцоотой ханган, биелэлтийг жил бүрийн 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор Гадаад харилцааны яаманд хүргүүлж байхыг холбогдох Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлаг, байгууллагын дарга нарт даалгаж, Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Хүний эрхийн үндэсний комисс, Сонгуулийн ерөнхий хороонд тус тус зөвлөсүгэй.

3.Дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэгт даалгасугай:

3.1.Ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх холбогдох яамдын Төрийн нарийн бичгийн дарга, төрийн байгууллагын дарга, албан тушаалтан болон иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл бүхий ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих орон тооны бус зөвлөлийг байгуулж ажиллуулах;

3.2.Ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн 1 дүгээр сард багтаан энэ тогтоолын 3.1-д заасан орон тооны бус зөвлөлөөр хэлэлцүүлж, гарсан саналыг холбогдох байгууллагад хүргүүлэх;

3.3.Ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийн дунд хугацааны явц, үр дүнг энэ тогтоолын 3.1-д заасан орон тооны бус зөвлөлөөр 2028 оны 1 дүгээр сард хэлэлцүүлж, 2 дугаар сард багтаан Засгийн газарт танилцуулах;

3.4.Монгол Улсын хүний эрхийн төлөв байдлын тавдугаар тайланг ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэд тулгуурлан иргэний нийгмийн байгууллага болон холбогдох бусад байгууллагатай зөвшилцөн 2030 оны 6 дугаар сард багтаан боловсруулан Засгийн газарт танилцуулж, заасан хугацаанд илгээх.

4.Ерөнхий төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг харьяа нутаг дэвсгэртээ зохион байгуулах арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нар, уг үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэгт тус тус үүрэг болгосугай.

5.Ерөнхий төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүр улс болон орон нутгийн төсөвт тусгуулах арга хэмжээ авахыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгаж, Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Хүний эрхийн үндэсний комисс, Сонгуулийн ерөнхий хороонд тус тус зөвлөсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД** **Г.ЗАНДАНШАТАР**

**ГАДААД ХАРИЛЦААНЫ
САЙД** **Б.БАТЦЭЦЭГ**

Засгийн газрын 2026 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 73 дугаар тогтоолын хавсралт

## НҮБ-ЫН ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨВЛӨЛӨӨС ИРҮҮЛСЭН ЗӨВЛӨМЖҮҮДИЙГ 2026-2030 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Зөвлөмж (дугаартай) | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Хариуцах байгууллага | Хамтран хэрэгжүүлэх байгууллага |
|---|---|---|---|---|---|---|
| | Нэг.Олон улсын гэрээнд дотоодын хууль тогтоомжийг нийцүүлэх, хүний эрхийн гэрээний хэрэгжилтийг сайжруулах, хүний эрхийн олон улсын механизмтай хамтран ажиллах асуудал | | | | | |
| 1. | 105.5.НҮБ-ын системийн байгууллагууд болон хүний эрхийн механизмтай үргэлжлүүлэн хамтран ажиллах (Арабын Нэгдсэн Эмират Улс) | НҮБ-ын хүний эрхийн байгууллага, тэр дундаа Хүний эрхийн зөвлөлийн тусгай процедур, гэрээний байгууллагуудтай үргэлжлүүлэн хамтран ажиллах | Улсын төсөв | 1.Хамтын ажиллагааг үргэлжлүүлж, айлчлалыг зохион байгуулсан байна | Гадаад харилцааны яам | |
| 2. | 105.7.Айлчлал хэрэгжүүлэх тусгай мандат эзэмшигчдэд нээлттэй, байнгын урилга илгээх (Парагвай) | | | | | |
| 3. | 105.8.Дотоодын шүүхүүд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактыг хэрэг хянан шийдвэрлэхдээ хэрэглэдэг байдлыг нэмэгдүүлэх (Колумби) | Шүүгчдэд олон улсын гэрээг сурталчлан таниулах, холбогдох агуулгыг сургалтын хөтөлбөрт тусгаж, сургалтыг үе шаттай зохион байгуулах | Улсын төсөв<br><br>Төсөл, хөтөлбөр | 1.Пактын талаарх шүүгчдийн мэдлэг, ойлголт нэмэгдсэн байна | 1.Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академи | Улсын дээд шүүх<br><br>Бүх шатны шүүх |
| 4. | 105.9.Дотоодын хууль тогтоомжийг олон улсын хүний эрхийн стандартад нийцүүлэх (ОХУ) | Дотоодын хууль тогтоомжийг конвенцод нийцэж байгаа эсэхэд үнэлгээ хийж, нийцүүлэх арга хэмжээ авах (онц байдал, нийгмийн халамж зэрэг) | Улсын төсөв | 1.Зохих судалгаа хийсэн байна<br><br>2.Нийцүүлэхээр авсан арга хэмжээний тоо, оноор | Холбогдох яамд | |
| 5. | 105.17.Тайлагнах, хэрэгжүүлэх, хяналт тавих үндэсний механизм байгуулах, механизмд холбогдох бүх байгууллага, тэр дундаа иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах (Мавритани) | 1.Монгол Улсын олон улсын гэрээ болон НҮБ-ын гэрээний хороодоос өгсөн зөвлөмжийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, тайлагнах хүчин чармайлт гаргах | Улсын төсөв | 1.Хүчин чармайлт гаргасан байна<br><br>2.Механизмыг байгуулж, байнгын арга хэмжээг нь | Холбогдох байгууллага | Иргэний нийгмийн байгууллага |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 6. | 105.18.Тайлагнах, хэрэгжүүлэх, хяналт тавих үндэсний механизм байгуулахыг судлах, ингэхдээ механизмын талаарх Марракешийн зөвлөмжийг анхааралдаа авах (Марокко) | 2.Монгол Улсын олон улсын гэрээ болон НҮБ-ын гэрээний хороодоос өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих механизмыг иргэний нийгмийн байгууллагын оролцоотойгоор байгуулж, тогтмол ажиллуулах | | хангах арга хэмжээ авсан байна | | |
| 7. | 105.19.Тайлагнах, хэрэгжүүлэх, хяналт тавих үндэсний механизмын арга хэмжээг бэхжүүлэх, арга хэмжээг нь үр дүнтэй байлгах (Азербайжан) | | | | | |
| 8. | 105.20.Хүний эрхийн зөвлөмжүүдийн хэрэгжилтийг тайлагнах, хэрэгжүүлэх, хяналт тавих үндэсний механизмыг дахин байгуулах, энэхүү зорилгоор хамтран ажиллах саналыг хүлээн авах боломжийг судлах (Парагвай) | | | | | |
| 9. | 105.129.Тогтвортой хөгжил 2030 хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, ингэхдээ олон улсын гэрээгээр хүлээсэн хүний эрхийн үүргийг хэрэгжүүлж буй эсэхэд анхаарал тавих (Казахстан) | "Тогтвортой хөгжил 2030" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх | Улсын төсөв<br><br>Төсөл, хөтөлбөр | Хэрэгжүүлсэн байна | Холбогдох байгууллага | Иргэний нийгмийн байгууллага |
| 10. | 105.130.Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын хүн амд илүү сайн боломжуудыг олгоход үзүүлж буй манлайллаа үргэлжлүүлэх (Боливи) | Манлайллаа үргэлжлүүлэх | Улсын төсөв | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, оноор | Гадаад харилцааны яам | Холбогдох бусад байгууллага |
| Хоёр.Хүний эрхийн Үндэсний Комиссыг бэхжүүлэх асуудал | | | | | | |
| 11. | 105.10.Хүний эрхийн Үндэсний Комиссыг хүний нөөцийн, техникийн болон санхүүгийн хангалттай эх үүсвэрээр хангах замаар бүрэн эрхээ үр дүнтэй, хараат бусаар эдлэх нөхцөл бүрдүүлэх (Монтенегро) | 1.Комиссын ажилтан, албан хаагчдын ажил, үүргийн хуваарилалт, ажлын байрны тодорхойлолтод үнэлгээ хийх замаар хүний нөөцийн хэрэгцээ, шаардлагыг бодитоор тодорхойлох<br><br>2.Хүний нөөцийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлж шаардлагатай ажилтан, албан хаагч ажиллуулах арга хэмжээ авах | Улсын төсөв<br><br>Төсөл хөтөлбөр | 1-2.Хүний эрхийн Үндэсний Комиссын хүний нөөцийн хэрэгцээ хангагдсан байна<br><br>3.Үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөл бүрдсэн байна.<br><br>4.Монгол Улсын | Хүний эрхийн Үндэсний Комисс<br><br>Сангийн яам<br><br>Хууль зүй, дотоод хэргийн яам | Хууль зүйн үндэсний хүрээлэн |
| 12. | 105.11.Хүний эрхийн Үндэсний Комисст хүний нөөцийн, техникийн болон санхүүгийн хангалттай эх үүсвэр хуваарилах замаар бүрэн эрхээ үр дүнтэй, хараат бусаар эдлэх нөхцөл бүрдүүлэх (Индонез) | | | | | |
| 13. | 105.12.Хүний нөөцийн болон санхүүгийн | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | хангалттай эх үүсвэрээр хангах замаар Хүний эрхийн Үндэсний Комиссыг бэхжүүлэх (Марокко) | 3.Комиссын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах санхүүжилтийг жил бүрийн Төсвийн тухай хуульд тусгах<br><br>4.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийг боловсронгуй болгох<br><br>5.Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх<br><br>6.Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг олон нийтэд сурталчлан таниулах | | Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийг Парисын зарчимд нийцүүлсэн байна<br><br>5.Холбогдох үнэлгээг хийсэн байна<br><br>6.Зохион байгуулсан ажлын тоо, оноор | | |
| 14. | 105.13.Хүний эрхийн Үндэсний Комиссын эрх зүйн зохицуулалт, санхүүжилтийг Парисын зарчимд нийцүүлэх замаар тус байгууллагыг бэхжүүлэх (Боливи) | | | | | |
| 15. | 105.14.Парисын зарчимд нийцүүлэн Хүний эрхийн Үндэсний Комиссын үйл ажиллагаа, захиргаа удирдлага, санхүүгийн бие даасан байдлыг хангах хууль тогтоомжийн болон санхүүжилтийн арга хэмжээ авах (Мексик) | | | | | |
| 16. | 105.15.Хүний эрхийн Үндэсний Комиссын бие даасан байдал болон бүс нутгийн оролцоог улам нэмэгдүүлэх (Азербайжан) | | | | | |
| 17. | 105.16.Үндэсний хүний эрхийн байгууллагуудыг бэхжүүлэх хүчин чармайлтаа үргэлжлүүлэх (Казахстан) | | | | | |
| 18. | 105.53.Хүний эрх хамгаалагчдыг дайралт, аюул заналхийлэл, айлган сүрдүүлэлтээс хамгаалах, ялангуяа Хүний эрх хамгаалагчдын хорооны санхүүжилтийг бэхжүүлэх (Франц) | | | | | |
| 19. | 105.114.Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг түгээх, хэрэгжилтийг сайжруулах, ялангуяа Хүний эрх хамгаалагчийн хороонд гомдол гаргах чиглэлээр хуулийг түгээх (Испани) | | | | | |
| Гурав.Жендэрийн тэгш байдлын асуудал | | | | | | |
| 20. | 105.22.“Жендэрийн мэдрэмжтэй ажлын байр” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хурдасгаж, эмэгтэйчүүдийн төлөөлөл болон хөдөлмөрийн аюулгүй нөхцөлийг хангах хэмжигдэхүйц зорилт дэвшүүлэх замаар ажлын байр дахь жендэрийн тэгш байдлыг нэмэгдүүлэх | 1.Хүний хөдөлмөрлөх эрх, хөдөлмөрийн аюулгүй нөхцөлөөр хангах зорилгоор ажил олгогч, даатгуулагч, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЭА)-н зөвлөлийн гишүүдэд чиглэсэн | Улсын төсөв<br><br>Төсөл, хөтөлбөр | 1.Нийслэлийн 9 дүүрэг, 21 аймаг, 42 суманд ажил олгогч, даатгуулагч, ХАБЭА-н зөвлөлд зориулсан | 1.Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам<br><br>2.Жендэрийн | 1.Нийгмийн даатгалын ерөнхий газар<br><br>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | ажлаа үргэлжлүүлэх (Мальдив) | хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг үндэсний түвшинд зохион байгуулах<br>2.“Ажил, ар гэр амьдралын тэнцвэр”-ийг хангах стратеги удирдамж боловсруулж, ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх арга хэмжээ тогтмол зохион байгуулах<br><br>3.Байгууллагын “Хүний нөөцийн дүрэм”, “Дотоод журам”, ажилтны албан тушаалын тодорхойлолтод холбогдох заалтуудыг тусгаж, хэрэгжилтийг зохион байгуулах<br><br>4.Жендэрийн мэдрэмж, соёлтой хамт олон, ажлын байрыг бий болгох нөлөөллийн аян зохион байгуулах | | ХАБЭА-н сургалтыг зохион байгуулсан байна<br><br>2.“Ажил, ар гэр амьдралын тэнцвэр”-ийг хангах стратеги удирдамж боловсруулсан байна<br><br>“Ажил, ар гэр амьдралын тэнцвэр”-ийн талаарх нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулсан байна<br><br>3.Баримт Бичгүүдийг шинэчилсэн байна<br><br>4.Зохион байгуулсан арга хэмжээний тоо, оноор | үндэсний хорооны Ажлын алба | мэндийн төв<br><br>2-4.Төрийн бүх байгууллага |
| 21. | 105.24.Жендэрийн тэгш байдлыг бодитоор хангах тусгай, түр арга хэмжээ авах (Доминиканы Бүгд Найрамдах Улс) | 1.Жендэрийн тэгш байдлыг бодитоор хангах тусгай, түр арга хэмжээг хэрэгжүүлэх зөвлөмж боловсруулах<br><br>2.Жендэрийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх | Улсын төсөв | 1.Тусгай, түр арга хэмжээний зөвлөмжийг боловсруулсан байна<br><br>2.Төлөвлөгөөг баталж хэрэгжүүлсэн байна | Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба | Төрийн төв болон орон нутгийн бүх байгууллага |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 22. | 105.25.Нийгмийн амьдралын бүхий л салбарт жендэрийн тэгш байдлыг хангах, мэдлэгийг дээшлүүлэх тодорхой арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх (Венесуэл, Боливи) | 1.Бүх нийтэд хүний эрх, жендэрийн боловсрол олгох үндэсний тогтолцоог хөгжүүлэх<br><br>2.Жендэрийн тухай ойлголт, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нөлөөллийн ажил зохион байгуулах | | 1.Жендэрийн сургагч багш, нарын тоо 689 (Анхан шат 600, Дунд шат 50, ахисан шат 39)<br><br>2.Зохион байгуулсан ажлын тоо, оноор | Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба<br><br>Цагдаагийн ерөнхий газар | 2.Хүний эрхийн Үндэсний Комисс<br><br>Иргэний нийгмийн байгууллага |
| 23. | 105.26.Эмэгтэйчүүдийн эрх тэгш байдлыг хангах, ялангуяа шийдвэр гаргах болон удирдлагын түвшинд хангах, мөн орон нутаг дахь эмэгтэйчүүдийн боловсрол эзэмших, эрүүл мэндийн үйлчилгээ авах нөхцөлийг сайжруулах чиглэлээр хууль тогтоомж, шинэ санал санаачилга батлах асуудлыг авч үзэх (Словени) | Удирдах ажилтны цахим сургалтад төр, хувийн хэвшлийн удирдах ажилтнуудыг хамруулж, тэдний мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх | | Удирдах ажилтны цахим сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан удирдах ажилтны хувь 14 хувь байна | Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба | |
| 24. | 105.136.Жендэрийн тэгш байдлыг дэмжсэн, жендэрт суурилсан хүчирхийллээс сэргийлсэн, хүчирхийлэгчдэд хариуцлага ногдуулсан, эмэгтэйчүүдийн боловсрол эзэмших, хөдөлмөр эрхлэх, улс төрд оролцох, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээнд адил тэгш хамрагдахыг баталгаажуулсан хууль тогтоомж болон нийтийн бодлогыг бэхжүүлэх (Коста-Рика) | 1.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үзэл баримтлалыг салбарын хууль тогтоомжид тусгах<br><br>2.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх<br><br>3.Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян арга хэмжээг жил бүр зохион байгуулах | Улсын төсөв | 1.Салбарын хууль тогтоомжид тусгагдсан байна<br><br>2.Төлөвлөгөөг хэрэгжүүлсэн байна<br><br>3.Арга хэмжээг жил бүр зохион байгуулсан байна | Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба | Холбогдох бүх байгууллага |
| 25. | 105.78.Мэдээлэл хамгаалах, мэдээллийн эрх чөлөө, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зэрэг хүний эрхийг цахим орчинд хамгаалах явдлыг сайжруулах (Мозамбик) | 1.Цахим орчинд хувь хүний мэдээллийг хамгаалах, хувийн мэдээлэл хамгаалах тухай олон нийтийн ойлголт, мэдлэгийг сайжруулах<br><br>2.Хэвлэл мэдээлэл, урлагийн бүтээлийн агуулга, тэдгээртэй | Улсын төсөв | 1.Зохион байгуулсан арга хэмжээний тоо, хамрагдсан хүний тоо, оноор<br><br>2.Хяналт тавих механизм | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам<br><br>Жендэрийн үндэсний | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | холбогдон нийгмийн сүлжээгээр тархах мэдээлэлд жендэрийн өнцгөөс хяналт тавих олон нийтийн механизм бий болгох<br><br>3.Хүний эрхийг цахим орчинд хамгаалах чиглэлээр урьдчилан сэргийлэх, сурталчлан таниулах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх<br><br>4.Жендэрийн эрх тэгш байдлыг цахим орчинд хамгаалах чиглэлээр төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран сургалт зохион байгуулах | | байгуулагдсан байна<br><br>3.Зохион байгуулсан арга хэмжээний тоо, оноор<br><br>4. Зохион байгуулсан сургалтын тоо, оролцогчдын тоо, оноор | хорооны Ажлын алба | Цагдаагийн ерөнхий газар<br><br>Харилцаа холбооны зохицуулах хороо<br><br>Мэргэжлийн холбоод<br><br>Иргэний нийгмийн байгууллага |
| 26. | 105.138.Нийгэм дэх жендэрийн тэгш байдлыг хангах, цахим орчин дахь жендэрт суурилсан хүчирхийлэл рүү чиглэсэн арга хэмжээ үргэлжлүүлэн авах (Япон) | 1.“Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээг бэхжүүлэх нь” төслийг боловсролын салбарт хэрэгжүүлэх<br><br>2.“Монгол Улсад жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэх нь” төслийг хэрэгжүүлэх<br><br>3.Сошиал орчинд жендэрийн тэгш байдлыг хангах, жендэрт суурилсан хүчирхийллийн эсрэг нөлөөллийн контент хийж түгээх | Төсөл, хөтөлбөр | 1-2.Төслүүдийг хэрэгжүүлсэн байна.<br><br>2.Түгээсэн контентын тоо, оноор | Боловсролын яам<br><br>Хууль зүй, дотоод хэргийн яам<br><br>Улсын дээд шүүх<br><br>Хүний эрхийн Үндэсний Комисс<br><br>Улсын ерөнхий прокурорын газар | Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба<br><br>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба<br><br>Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам |
| 27. | 105.139.Бүх шатны шийдвэр гаргах түвшинд, ялангуяа улс төр болон шүүхийн эрх мэдлийн хүрээнд эмэгтэйчүүдийн оролцоог үргэлжлүүлэн хангах (Армени) | 1.Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо, манлайллыг нэмэгдүүлэх арга хэмжээ авах | Улсын төсөв | 1.Шийдвэр гаргах түвшний эмэгтэйчүүдийн тоо нэмэгдсэн байна | Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба | Төрийн захиргааны бүх байгууллага |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 28. | 105.140.Засаглалын бүх шатны шийдвэр гаргах үйл явцад эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх (Иран) | 2.Улс төрийн хүрээ дэх хүйсийн тэнцвэрийг хангах талаар Улс төрийн намын тухай болон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд заасан квотыг хэрэгжүүлэх<br><br>3.Төрийн албаны удирдах албан тушаалд хүйсийн тэнцвэрт байдлыг хангаж нэр дэвшүүлэх, өрсөлдүүлэх шалгуурыг тогтоох | | 2.Хуульд заасан квотын хэрэгжилт (сонгуулийн жилээр)<br><br>3.Шалгуурыг тогтоосон байна | | Сонгуулийн ерөнхий хороо |
| 29. | 105.141.Бүх шатны удирдлага болон шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог үргэлжлүүлэн бэхжүүлэх (Этиоп) | | | | | |
| 30. | 105.142.Улс төрд оролцох эмэгтэйчүүдийн оролцоог үргэлжлүүлэн хангах, удирдах албан тушаал дахь тэдний оролцоог бэхжүүлэх (Оман) | | | | | |
| 31. | 105.143.Адил тэгш боломж, үр дүнтэй оролцоог хангах замаар эмэгтэйчүүдийн эрх, боломжийг парламентын төлөөллөөр хязгаарлахгүйгээр өргөжүүлэх (Мозамбик) | | | | | |
| 32. | 105.145.Бүх салбарт эмэгтэйчүүдийн төлөөллийг хангах хүчин чармайлтаа үргэлжлүүлэх (Бутан) | | | | | |
| 33. | 105.144.Эмэгтэйчүүдэд ээлгүй, тэдний төлөөлөл багатай салбарууд дахь эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээ авах (Колумби) | | | | | |
| 34. | 105.146.Шийдвэр гаргах түвшний байгууллага дахь эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх арга хэмжээгээ үргэлжлүүлэх (Непал) | | | | | |
| 35. | 105.147.Үндэсний болон орон нутгийн байгууллага дахь эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх арга хэмжээгээ үргэлжлүүлэх (Бангладеш) | | | | | |
| 36. | 105.148 Улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралд эмэгтэйчүүдийн идэвхтэй оролцоог хангах чиглэлээр бодлого, санал санаачилгыг үргэлжлүүлэн бэхжүүлэх, ингэхдээ мэргэжлийн сургалт, ажлын байрны дэмжлэг, манлайллын хөтөлбөр зэргийг тусгах (Куба) | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Дөрөв.Ялгаварлан гадуурхах бүх хэлбэртэй тэмцэх асуудал | | | | | | |
| 37. | 105.23.Хөдөлмөрийн зах зээл дэх ялгаварлан гадуурхалтыг устгах, эрх тэгш байдлыг хангах, хүйсээр нь ялгаж цалинжуулдаг байдлыг бууруулах хүчин чармайлтаа нэмэгдүүлэх (Непал) | 1.Зөвлөмжид дурдсан асуудлаар ажил олгогч, ажилтны мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх арга хэмжээ авах<br><br>2.Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтэд үр дагаврын үнэлгээ хийх замаар зөвлөмжид дурдсан асуудлын нөхцөл байдлыг тодорхойлох<br><br>3.Дээрх үнэлгээний дүнд үндэслэж бууруулах арга хэмжээг үе шаттай төлөвлөж, хэрэгжүүлэх | Улсын төсөв<br><br>Төсөл, хөтөлбөр | 1.Ойлголт, мэдлэг нэмэгдүүлэх арга хэмжээг давтамжтай авч хэрэгжүүлсэн байх<br><br>2.Үр дагаврын үнэлгээг хийсэн байх<br><br>3.Төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлсэн байна | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Яам, харьяа байгууллага |
| 38. | 105.27.Эмзэг бүлгийнхэн, түүн дотор ЛГБТАй хүмүүсийг ялгаварлан гадуурхалтаас хамгаалахын тулд бүх хэлбэрийн ялгаварлан гадуурхалтын эсрэг хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлэх, үзэн ядах гэмт хэргийг шуурхай, хараат бусаар мөрдөн шалгах, хууль сахиулах албан хаагчид болон төрийн албан хаагчдыг давтан сургах (Швейцар) | 1.Эмч, сувилагч, багш, эрх зүйч, шүүгч, прокурор, цагдаа, цэрэг зэрэг мэргэжилтэн бэлтгэдэг мэргэжлийн болон дээд боловсролын сургалтын хөтөлбөрт хүний эрх, бүх төрлийн ялгаварлан гадуурхалт, холбогдох хууль тогтоомж, олон улсын хүний эрхийн конвенц, стандартын талаар агуулга тусгах<br><br>2.Хууль сахиулах, цэрэг, эмч, эмнэлгийн ажилтан болон төрийн бүх шатны албан хаагчдын сургалтын хөтөлбөрт хүний эрх, ялгаварлан гадуурхалтын талаарх сургалтын агуулга тусгах, сургалтад хамруулах<br><br>3.Бүх нийтийн хүний эрхийн мэдлэг, ялгаварлан гадуурхалтын талаарх | Улсын төсөв<br><br>Төсөл, хөтөлбөр | 1.Дурдсан агуулгыг тусгасан сургалтын хөтөлбөрийн тоо<br><br>2.Сургалтын тоо, хамрагдсан төрийн албан хаагчдын тоо, оноор, бүс нутгаар<br><br>3.Кампанит ажлын тоо, оноор | Боловсролын яам<br><br>Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академи<br><br>Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэн<br><br>Цагдаагийн ерөнхий газар<br><br>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх | Хүний эрхийн Үндэсний Комисс<br><br>Хууль зүй, дотоод хэргийн яам<br><br>Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам<br><br>Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам<br><br>Батлан хамгаалах яам |
| 39. | 105.218.Ялгаварлан гадуурхлын эсрэг хууль тогтоомжоо бэхжүүлэх, бүрэн хэрэгжүүлэх замаар ЛГБТАй иргэдийг бүх хэлбэрээр ялгаварлан гадуурхал, хүчирхийлэхээс үр дүнтэй хамгаалах (Чили); | | | | | |
| 40. | 105.222.Олон нийтийн мэдлэг, ойлголтыг сайжруулах кампанит ажил зохион байгуулах болон цагдаагийн алба хаагчид, бусад оролцогч талуудыг сургалтад хамруулах замаар гэр бүлийн хүчирхийлэл, ЛГБТАй иргэдийн эсрэг хүчирхийлэл, ялангуяа хөдөө, орон нутагт үйлдэгдэж буй эдгээр | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | хүчирхийлэлтэй тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах (Швейцар); | ойлголтыг сайжруулах кампанит ажлыг зохион байгуулах<br><br>4.Эмч, сувилагч, багш, эрх зүйч, шүүгч, прокурор, цагдаа, цэрэг зэрэг мэргэжилтний мэргэжлийн ёс зүйн дүрэмд ялгаварлан гадуурхалтыг хориглох | | | ерөнхий газар<br><br>Зэвсэгт хүчний жанжин штаб<br><br>Эрүүл мэндийн яам | Иргэний нийгмийн байгууллага |
| 41. | 105.209.Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, мэргэжлийн ёс зүйн дүрмийг боловсруулах замаар ЛГБТ+ иргэдийг ялгаварлан гадуурхалтаас хамгаалах (ИБУИНХУ); | | | | | |
| Тав.Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэхийн эсрэг арга хэмжээ авах чиглэлээр | | | | | | |
| 42. | 105.29.Эрүү шүүлт тулгах, хэрцгий харьцах явдлыг устгах талаар дорвитой арга хэмжээ авах, үүний тулд төрийн албан хаагчийн үйлдсэн үйлдлийг мөрдөн шалгадаг хараат бус механизм байгуулах тухай хууль тогтоомж батлах, тухайн хууль тогтоомжид мөрдөн байцаагч нь уг хэрэгт сэжиглэгдсэн этгээдтэй албаны болон босоо удирдлагын ямар ч холбоогүй байхыг баталгаажуулах (Украин) | 1.Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн талаар гомдол, мэдээлэл хүлээн авах, хараат бусаар мөрдөн шалгах бие даасан механизмыг бий болгох чиглэлээр холбогдох судалгаа хийж, түүнд үндэслэн хуулийн төсөл боловсруулах<br><br>2.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаар мөрдөгч, прокурор, эрх бүхий байгууллагын албан тушаалтнуудын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалтын хөтөлбөр боловсруулж, сургалтад алба хаагчдыг хамруулах<br><br>3.Хууль сахиулах байгууллагын алба хаагч бэлтгэх ангиудын сургалтад эрүү шүүлтээс ангид, шударгаар шүүлгэх эрхийн агуулгыг тусгах | Улсын төсөв<br><br>Төсөл, хөтөлбөр | 1.Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна<br><br>2.Сургалтын тоо, хамрагдсан хүний тоо, оноор<br><br>3.Сургалтын хөтөлбөрт уг агуулга тусгагдсан байна | 1.Хууль зүй, дотоод хэргийн яам<br><br>2.Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академи<br><br>Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэн<br><br>Цагдаагийн ерөнхий газар<br><br>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар<br><br>Дотоод хэргийн их | Хүний эрхийн Үндэсний Комисс |
| 43. | 105.30.Эрүү шүүлт тулгах, хэрцгий харьцах бүхий л үйлдлийг мөрдөн шалгах хараат бус механизмыг байгуулж ажиллуулах, хууль сахиулах албан хаагчдын хүний эрхийн мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх (Австри) | | | | | |
| 44. | 105.31.Эрүү шүүлт тулгах, хэрцгий харьцах явдлыг устгах, эдгээр үйлдлийн мөрдөн шалгах ажиллагааг хараат бус, ил тод явуулах нөхцөлөөр хангах хүчин чармайлтаа үргэлжлүүлэх (Польш) | | | | | |
| 45. | 105.47.Эрүү шүүлт тулгах болон хэрцгий харьцах хэрэгт мөрдөн байцаах хараат бус механизм бий болгох, улмаар хараат бус, хариуцлагатай байдлыг хангах (Чех) | | | | | |
| 46. | 105.48.Эрүү шүүлт тулгах болон хэрцгий харьцах хэргийн мөрдөн байцаалтыг шуурхай, үр дүнтэй явуулах (Доминикан) | | | | | |

| | | | | | | |
| 133. | 105.127.Агаарын бохирдлын эсрэг үр дүнтэй арга хэмжээ авч түүнээс үүдсэн эрүүл мэндийн эрсдэлийг бууруулахын тулд шуурхай ажиллах (Герман) | 1.Гэр хорооллыг орон сууцжуулах үйл хэргээ эрчимжүүлэх<br><br>2.Дэд төвүүдийг бүрэн ашиглалтад оруулах<br><br>3.Хийн болон сэргээгдэх эрчим хүчинд шилжихэд нь гэр хорооллын өрхөд дэмжлэг үзүүлэх<br><br>4.Нийтийн тээврийг илүү хүртээмжтэй болгох<br><br>5.Орчны бохирдлоос иргэдийг урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, хяналт тавих | Улсын төсөв<br><br>Хувийн хэвшил<br><br>Төсөл, хөтөлбөр | 1-4.Агаарын бохирдлыг багасгасан байна<br><br>5.Орчны бохирдлоос урьдчилан сэргийлэхээр авсан арга хэмжээний тоо, оноор | Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар<br><br>Эрүүл мэндийн яам | |
| | Арван зургаа.Бүх төрлийн хүчирхийлэлтэй тэмцэх асуудал | | | | | |
| 134. | 105.149.Гэр бүлийн хүчирхийлэлтэй | 1.Гэр бүлийн хүчирхийлэлтэй | Улсын | 1-4.Хуульд | 1-4.Гэр бүл, | 1-4.Хүний |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | тэмцэх тухай хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэх, мөн хохирогчдыг хамгаалах, туслах үүргээ биелүүлэхэд нь шаардагдах сургалтад шүүх эрх мэдлийн болон цагдаагийн эрх бүхий албан хаагчид, нийгмийн болон эрүүл мэндийн ажилтнуудыг хамруулдаг байх (Австри) | тэмцэх тухай хуульд хэрэгжилтийн үнэлгээ хийж, хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэх арга хэмжээ авах<br><br>2.Хохирогчдыг хамгаалах, туслалцаа үзүүлэхэд шаардлагатай мэдлэгийг салбарынхаа хүрээнд тодорхойлж, сургалтын хөтөлбөр, агуулгад тусгах, шаардлагатай заавар, зөвлөгөө, аргачлал боловсруулж албан хаагчдад түгээх<br><br>3.Зөвлөмжид дурдсан салбарын албан хаагчид, болон орон нутгийн төрийн захиргааны байгууллагын албан хаагчдыг дээрх чиглэлийн сургалтад тогтмол хамруулах<br><br>4.Хүүхдийн эсрэг гэмт хэргийн криминалистик шинж, мөрдөх арга зүйн онцлог (Хүний эрхийн мэдрэмжтэй ажиллах арга зүй) зэрэг сэдвүүдийг хууль сахиулах албан хаагч бэлтгэх их сургуулийн сургалтын хөтөлбөрт тусгах<br><br>5.Эмнэлэгт түшиглэсэн "Нэг цэгийн үйлчилгээний төв"-ийн стандартыг батлах | төсөв<br><br>Төсөл, хөтөлбөр | хэрэгжилтийн үнэлгээ хийсэн байна<br><br>Сайжруулсан сургалтын хөтөлбөрийн тоо<br><br>Боловсруулсан заавар, зөвлөгөө, аргачлалын тоо<br><br>Сургалтын тоо, хамрагдсан албан хаагчид, оноор<br><br>5.Стандарт батлагдсан байна | хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам<br><br>Хууль зүй, дотоод хэргийн яам<br><br>Эрүүл мэндийн яам<br><br>Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар<br><br>Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академи<br><br>Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэн<br><br>5.Эрүүл мэндийн яам<br><br>Стандартчлал, хэмжил зүйн үндэсний төв | эрхийн Үндэсний Комисс<br><br>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба<br><br>Цагдаагийн ерөнхий газар<br><br>Дотоод хэргийн их сургууль<br><br>Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар<br><br>Иргэний нийгмийн байгууллага |
| 135. | 105.150.Бэлгийн болон жендэрт суурилсан хүчирхийллээс үр дүнтэй сэргийлж хариу арга хэмжээ авах чиглэлээр сургалт зохион байгуулах зэргээр Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах (Исланд) | | | | | |
| 136. | 105.152.Холбогдох бүх албан хаагчдыг сургах, хохирогчид дэмжлэг үзүүлэх үйлчилгээг сайжруулах замаар Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэх хүчин чармайлтаа эрчимжүүлж (Монтенегро) | | | | | |
| 137. | 105.151.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн үр дүнтэй хэрэгжилтийг хангах хүчин чармайлтаа эрчимжүүлж иж бүрэн үндэсний арга хэмжээны төлөвлөгөө боловсруулах (Румын) | | | | | |
| 138. | 105.157.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн үр нөлөөний үнэлгээний зөвлөмжийг үр дүнтэй хэрэгжүүлэх (Бутан) | | | | | |
| 139. | 105.158.Шүүгч, прокурор, цагдаагийн алба хаагч, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч болон эрүүл мэндийн ажилтныг тусгайлсан сургалтад хамруулах замаар Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах (Коста-Рика) | | | | | |
| 140. | 105.159.Хамгаалах байр ба үзүүлэх тусламж үйлчилгээ, мэргэжлийн албан | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | хаагчдыг сургах, мөн хохирогч төвтэй хандлага, олон нийтийн ойлголт зэргийг нэмэгдүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг олгох замаар гэр бүлийн болон жендэрт суурилсан хүчирхийллийн хуулийн хэрэгжилтийг сайжруулах (Чех) | | | | | |
| 141. | 105.170.Гэр бүлийн болон жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх хүчин чармайлтаа үргэлжлүүлэх (Узбекистан) | | | | | |
| 142. | 105.153.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэх, хангалттай санхүүжилт олгох замаар гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх арга хэмжээг эрчимжүүлэх (Молдова) | 1.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Хүүхэд хамгааллын тухай зэрэг хууль тогтоомжид заасан түр хамгаалах байртай холбоотой хууль тогтоомжуудын хэрэгжилтийг бүрэн хангах<br><br>2.Түр хамгаалах байрны нөхцөл байдал, стандарт, үйлчилгээ үзүүлэх журмын хэрэгжилтэд хяналт тавих, сайжруулах<br><br>3.Хүчирхийллийн хохирогчдод үзүүлэх тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх<br><br>4.Нийслэл дэх Түр хамгаалах байрыг хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настнуудад үйлчилгээ үзүүлэх чиглэлээр төрөлжүүлж, санхүүжилтийг хуулийн дагуу шийдвэрлэх<br><br>5.Жендэрт суурилсан | Улсын төсөв<br><br>Төсөл, хөтөлбөр | 1.Түр хамгаалах байрны орчин, нөхцөл, санхүүжилт сайжирсан байна<br><br>2.Тусламж, үйлчилгээ нэр, төрөл нэмэгдсэн байна<br><br>3.Тусламж, үйлчилгээ хүртсэн иргэдийн тоо, хүйс болон оноор<br><br>4.Түр хамгаалах байр төрөлжиж, санхүүжилт тогтмол нэмэгдсэнээр аюулгүй байдал, чанар сайжирсан байна<br><br>5.Үндэсний судалгааг хийсэн байна | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам<br><br>Хууль зүй, дотоод хэргийн яам<br><br>Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн<br><br>Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар<br><br>8-9.Эрүүл мэндийн яам | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба<br><br>Цагдаагийн ерөнхий газар<br><br>Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар<br><br>Сангийн яам<br><br>Иргэний нийгмийн байгууллага |
| 143. | 105.154.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлж жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчид үзүүлэх тусламжийг сайжруулах (Гамби) | | | | | |
| 144. | 105.155.Жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогч эмэгтэйчүүдэд үзүүлэх тусламж, үйлчилгээг сайжруулах зэрэг арга хэмжээ авах замаар Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэх хүчин чармайлтаа эрчимжүүлж, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод үзүүлж буй бүх туслалцаа хохирогч төвтэй, жендэрийн мэдрэмжтэй бөгөөд учирсан гэмтэл хохирлыг арилгахад чиглэгдсэн байх нөхцөлийг хангах (Хорват) | | | | | |
| 145. | 105.156.Жендэрт суурилсан хүчирхийллийн даван туулагчдад зориулсан тусламж үйлчилгээ болон бэлгийн хүчирхийлэгчдийн бүртгэл зэргээр Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг үр | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | дүнтэй хэрэгжүүлэх (Испани) | хүчирхийллийн үндэсний хоёр дахь судалгаа хийх<br><br>6.“Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргах журам”-д өөрчлөлт оруулах<br><br>7.Хүчирхийлэлд өртөж хохирсон хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамгаалах, хариу арга хэмжээг яаралтай авах “Хамтарсан баг”-ийн чадавхжуулах сургалтыг үе шаттай зохион байгуулах<br><br>8.Хүчирхийлэлд өртсөн хохирогчдод үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний олон улсын чанарын протоколыг нэвтрүүлэх<br><br>9.Эмнэлэг түшиглэсэн “Нэг цэгийн үйлчилгээний төв”-ийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнээс бусад нэг хүнд ногдох хувьсах зардлын өртгийг тооцож санхүүжүүлэх | | 6.Журамд өөрчлөлт орсон байна<br><br>7.Сургалтыг тогтмол зохион байгуулсан байна<br><br>8.Чанарын протоколыг нэвтрүүлсэн байна<br><br>9.Санхүүжилтийн хэмжээ оноор | | |
| 146. | 105.160.Хохирогчдыг аюулгүй орон байр, сэтгэл заслын үйлчилгээнд хамруулах чиглэлээр Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан хамгаалах байрны санхүүжилтийг нэмэгдүүлж хуулийн хэрэгжилтийг хангах (Канад) | | | | | |
| 147. | 105.161.Эмэгтэйчүүд, охидын хүчирхийллийн эсрэг иж бүрэн хариу арга хэмжээ авах арга хэмжээнд хангалттай санхүүжилт олгож, тусгайлсан сургалт явуулах замаар Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах (Чили) | | | | | |
| 148. | 105.163.Хохирогчдыг хамгаалах, тэдэнд тусламж үйлчилгээ үзүүлэх, хамгаалах байрны санхүүжилтийг нэмэгдүүлэх замаар гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, тэмцэх хуулийг бүрэн хэрэгжүүлэх (Люксембург) | | | | | |
| 149. | 105.164.Боловсрол, сургалт, урьдчилан сэргийлэх, тусламж үйлчилгээ болон хууль зүйн механизмын санхүүжилт, сургалтыг нэмэгдүүлэх зэргээр бэлгийн болон жендэрт суурилсан хүчирхийллийн эсрэг иж бүрэн стратегийг хэрэгжүүлэх (Австрали) | | | | | |
| 150. | 105.167.Хамгаалах байр, үзүүлэх тусламж үйлчилгээнд хангалттай санхүүжилт олгох замаар эмэгтэйчүүд, хүүхдүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлж шийдвэрлэх механизмыг бэхжүүлэх (Азербайжан) | | | | | |
| 151. | 105.162.Эмэгтэйчүүдийн эсрэг бэлгийн болон гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хариуцлага тооцох институц, эрх зүйн зохицуулалт болон төрийн бодлогыг сайжруулж хохирогчдод | 1.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийг боловсронгуй болгох | Улсын төсөв | 1-3.Хуулийн төслүүдийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна | Хууль зүй, дотоод хэргийн яам<br><br>Гэмт хэргээс | Сангийн яам<br><br>Цагдаагийн ерөнхий газар |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | зүй зохистой тусламж үйлчилгээ үзүүлэх (Парагвай) | 2.Гэр бүлийн тухай хуулийг боловсронгуй болгох<br><br>3.Гэр бүлийг дэмжих хууль зүйн орчныг бүрдүүлэх<br><br>4.Бүх төрлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн кампанит арга хэмжээ тогтмол явуулах<br><br>5.Хүүхэд, эмэгтэйчүүдийг бүх төрлийн хүчирхийллээс хамгаалах арга хэмжээний санхүүжилтийг үе шаттай нэмэгдүүлэх<br><br>6.“Чанартай амьдрал-гэр бүлийн гишүүдийн оролцоо” хөтөлбөрийг хэрэгжүүлэх<br><br>7.Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийг бүх аймаг, дүүрэгт төр, хувийн хэвшлийн түншлэлээр ажиллуулж, гэр бүлд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, гэр бүлийн гишүүдийн ёс зүйн хариуцлагыг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх<br><br>8.Хохирогч, охид, эмэгтэйчүүдэд чиглэсэн хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэх | | 4.Зохион байгуулсан нөлөөллийн арга хэмжээний тоо, хамрагдсан хүн, оноор<br><br>5.Санхүүжилтийн хэмжээ, оноор<br><br>6.Хөтөлбөр хэрэгжсэн байна<br><br>7.Төвийг бүх аймаг, дүүрэгт байгуулж арга хэмжээ нь явагдаж байх<br><br>8.Үйлчилгээ авсан иргэдийн тоо, насны ангиллаар, оноор | урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба<br><br>Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам<br><br>Хууль зүйн туслалцааны төв | Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар<br><br>Монголын хуульчдын холбоо<br><br>Монголын Өмгөөлөгчдийн Холбоо |
| 152. | 105.165.Хохирогч төвтэй хууль баталж бүрэн хэрэгжүүлэх замаар гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хууль, эрх зүйн болон удирдлагын тогтолцоог бэхжүүлэх (Ирланд) | | | | | |
| 153. | 105.168.Эмэгтэйчүүд, охидын эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрээс урьдчилан сэргийлж хариу арга хэмжээ авах хууль, эрх зүйн болон удирдлагын тогтолцоог сайжруулах (Бангладеш) | | | | | |
| 154. | 105.169.Урьдчилан сэргийлэх болон хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж охид, эмэгтэйчүүдийг жендэрт суурилсан хүчирхийллээс хамгаалах арга хэмжээг гүнзгийрүүлэх (Норвег) | | | | | |
| 155. | 105.172.Цагдаагийн алба хаагчдын сургалт, хохирогчдод үзүүлэх тусламж үйлчилгээ болон олон нийтийн ойлголтыг сайжруулах замаар гэр бүлийн хүчирхийлэлд авах хариу арга хэмжээг сайжруулах (ИБУИНХУ) | | | | | |
| 156. | 105.171.Эмэгтэйчүүд, охидын эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлж тэмцэхэд чиглэгдсэн эрх зүйн шинэтгэлээ үргэлжлүүлэх (Марокко) | | | | | |
| 157. | 105.173.Жендэрт суурилсан, нэн ялангуяа бэлгийн хүчирхийллээс хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охидыг хамгаалах зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх зэрэг хүчин чармайлтаа үргэлжлүүлэх (Мальдив) | 1.Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, хүүхдүүдийг хүчирхийллээс хамгаалах зорилтод хөтөлбөр баталж, хэрэгжүүлэх | Улсын төсөв<br><br>Төсөл, хөтөлбөр | 1.Хөтөлбөр батлагдсан байна<br><br>2.Туршлагыг судалж нэвтрүүлэх арга хэмжээ авсан | 1-6.Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар<br><br>Гэмт хэргээс |

<table>
<tr><td>158.</td><td>105.174.Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охидыг нэн анхаарч жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх зорилтот хөтөлбөр хэрэгжүүлэх (Энэтхэг)</td><td rowspan="4">2.Бага насны хүүхдийн эсрэг хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэрэгт ял шийтгэгдсэн этгээдүүдийн талаарх хувийн мэдээллийг нийтэд ил болгодог гадаад орнуудын туршлагыг судалж нэвтрүүлэх<br><br>3.Шүүхээс гэм буруутайд тооцож, ял эдэлж байгаа хоригдол, эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан яллагдагч, насанд хүрээгүй хүний эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэг үйлдэж ял шийтгэгдсэн (педофил) этгээд, энэ төрлийн гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээдүүдийг хянах, хяналт тавих зорилго бүхий цахим санг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх<br><br>4.Хот, суурин газар, ЕБС, цэцэрлэг, дотуур байр зэрэг хүүхдийн орчныг бүрэн камержуулж байнгын хяналттай байлгах<br><br>5.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэдний хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх контент бэлтгэж, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчинд түгээх<br><br>6.Хүүхэд, гэрийн асаргаанд</td><td rowspan="4"></td><td rowspan="4">байна<br><br>3.Цахим сан ажиллаж эхэлсэн байна<br><br>4.Хот, орон нутагт камержуулалт бүрэн хийгдэж хяналт тавьдаг болсон байна<br><br>5.Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчинд түгээсэн контентын тоо<br><br>6.Зохион байгуулсан хяналт шалгалтын тоо<br><br>Гэр эргэлтээр илрүүлсэн хүчирхийллийн тоо, оноор</td><td rowspan="4">Хууль зүй, дотоод хэргийн яам<br><br>Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар<br><br>Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар<br><br>6.Эрүүл мэндийн яам</td><td rowspan="4">урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба<br><br>Цагдаагийн ерөнхий газар</td></tr>
<tr><td>159.</td><td>105.175.Гэр бүлийн хүчирхийллийн хүрээнд эмэгтэйчүүдийн эрх, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдийн эрхийн хамгаалалтыг сайжруулах (Польш)</td></tr>
<tr><td>160.</td><td>105.176.Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн эсрэг тэмцлийн хүрээнд хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулах иж бүрэн үр дүнтэй арга хэмжээ авах (Бельги)</td></tr>
<tr><td>161.</td><td>105.177.Хүүхдийн хөдөлмөр болон хүүхдийн эсрэг гэр бүлийн, бэлгийн хүчирхийлэлтэй хийх тэмцлээ үргэлжлүүлэх (Герман)</td></tr>
</table>

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | байдаг эмэгтэйчүүдийг хүчирхийллийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, хяналт шалгалт тогтмол зохион байгуулах, гэр эргэлтийн хүртээмжийг нэмэгдүүлэх | | | | |
| 162. | 105.182.Эмзэг бүлгийн хүүхэд, өсвөр настны иж бүрэн хамгааллыг онцгой анхаарч гэр бүлийн болон жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлж тэмцэх үндэсний хүчин чармайлтыг нэгтгэх (Куба) | 1.Хүүхэд, ялангуяа бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн хувийн нууцаа хамгаалуулах эрхийг бүрэн баталгаажуулсан эрх зүйн орчин бий болгох<br><br>2.Малчдыг гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, илрүүлэлтийг сайжруулах, хохирогчийг үр дүнтэй хамгаалах, арга зүйг бий болгох | Улсын төсөв | 1.Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна<br><br>2.Нөлөөллийн кампанит ажлын тоо, оролцогчдын тоо, оноор<br><br>Орон нутаг дахь эмзэг бүлгийн хүүхэд, өсвөр үеийн хохирогчийг хамгаалах арга зүйг нас, сэтгэхүйн онцлогт тохируулан баталж хэрэгжүүлсэн байна | Хууль зүй, дотоод хэргийн яам<br><br>Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам<br><br>Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба<br><br>Иргэний нийгмийн байгууллага<br><br>Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар |
| Арван долоо.Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын асуудал | | | | | | |
| 163. | 105.89.Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийг багасгах, ялангуяа хортой хөдөлмөр эрхлүүлэхгүй байхын тулд Олон улсын хөдөлмөрийн байгууллагын техникийн хамтын ажиллагааны хүрээнд хяналт шалгалтыг нэмэгдүүлэх, тэдгээрийг хангалттай санхүүжүүлэх (Бразил) | 1.Хүүхдийн хөдөлмөрийг таньж, илрүүлэх, холбон зуучлах заавар боловсруулж, батлуулах<br><br>2.Хүүхдийн эрхийн улсын байцаагч, салбарын хяналтын байцаагч нарыг чадавхжуулах<br><br>3.Насанд хүрээгүй хүүхдийг тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхлэхээс хамгаалах, хүүхдийн хөдөлмөрийг ашиглаж болзошгүй албан болон албан | Улсын төсөв | 1.Заавар баталсан байна<br><br>2.Сургалтад хамрагдсан хяналтын байцаагчдын тоо, оноор<br><br>3.Шалгалтын тоо, оноор<br><br>4.Нөлөөллийн арга | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам<br><br>Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар<br><br>Цагдаагийн | Иргэний нийгмийн байгууллага |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | бус салбарт цагдаагийн байгууллага, хүүхдийн эрхийн улсын байцаагч, хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч нар хамтран хяналт шалгалтыг жил бүр тогтмол хийх<br><br>4.Сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах | | хэмжээний тоо, оролцсон иргэдийн тоо, оноор | ерөнхий газар<br><br>Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар | |
| 164. | 105.178.Хүүхэд хамгаалал, бага насны хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх эрх зүйн орчныг үргэлжлүүлэн сайжруулах (Того) | Хүүхэд хамгаалал, бага насны хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох үр дүнтэй арга хэмжээ авах | Улсын төсөв | Арга хэмжээ авсан байна | Хууль зүй, дотоод хэргийн яам | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам<br><br>Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар |
| 165. | 105.179.Хүүхэд хамгааллыг сайжруулж, ялангуяа хөдөө, орон нутгийн хүүхэд хамгааллалд анхаарч цахим орчин дахь хүчирхийлэл болон үе тэнгийн дээрэлхэлтийн тухай ойлголт болон түүнээс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн хэрэгжилтийг үргэлжлүүлэх (Арабын Нэгдсэн Эмират Улс) | 1.Цахим орчинд хүүхдийг хортой болон хориотой агуулгаас урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн ажлыг үе шаттай, салбар дундын хамтын ажиллагаа, оролцоонд түшиглэн зохион байгуулах | Улсын төсөв<br><br>Төсөл, хөтөлбөр | 1.Зохион байгуулсан арга хэмжээний тоо, оролцогчдын тоо, оноор<br><br>2.Авсан арга хэмжээ, тоо, оноор | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам<br><br>Цахим хөгжил, | Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар<br><br>Аймаг, нийслэлийн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 166. | 105.183.Цахим дарамт, бага насны хүүхдүүдийг хор хөнөөлтэй контентоос сэргийлэх зорилгоор цахим боловсрол, оролцоог хангасан боловсролын кампанит ажлыг эрчимжүүлж үүнд зориулсан хүртээмжтэй арга хэрэгслийг нэвтрүүлэх (Куба) | 2.Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх арга хэмжээ авах<br><br>3.Үе тэнгийн дээрэлхэлт, цахим орчны ялгаварлан гадуурхалтын бодит статистик мэдээлэл цуглуулах, зорилгоор дэвшилтэд технологи ашиглан ерөнхий боловсролын сургуулийн сурагчдаас цахим санал асуулга авч, урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажил, арга хэмжээ зохион байгуулах<br><br>4.Хүүхдийг цахим орчинд хортой болон хориотой агуулгаас хамгаалах “Цахим орчны хяналтын баг” бүрдүүлж, арга хэмжээг идэвхжүүлэх, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон улсын туршлага (Green zone)-г судалж үйл ажиллагаанд нэвтрүүлэх | | 3.Улсын хэмжээнд зохион байгуулсан арга хэмжээний тоо, оноор<br><br>4.Цахим орчны хяналтын багийг байгуулж (Green zone) туршлагыг нэвтрүүлсэн байна | инновац, харилцаа холбооны яам<br><br>Боловсролын яам<br><br>Боловсролын ерөнхий газар | Засаг даргын Тамгын газар<br><br>Цагдаагийн ерөнхий газар |
| 167. | 105.180.Хүүхдийн эрхийг хамгаалахад чиглэсэн арга хэмжээг үргэлжлүүлэх (Гүрж) | 1.Иргэд, олон нийт тэр дундаа эцэг эх, асран хамгаалагч нарт зориулсан “Хүүхэд нэгдүгээрт” зан үйлд нөлөөлөх арга хэмжээг үе шаттайгаар тогтмол зохион байгуулах<br><br>2.Хүүхдийг болзошгүй эрсдэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх тогтолцоог иргэд, | Улсын төсөв | 1.Зохион байгуулсан арга хэмжээний тоо, оролцогчдын тоо, оноор<br><br>2.Урьдчилан сэргийлэх тогтолцоо бүрдсэн байна | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам<br><br>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг | Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар<br><br>Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | олон нийтийн оролцоотой бүрдүүлж, гэр бүл, нийгмийн орчин дахь хүүхэд хамгааллыг сайжруулна<br><br>3.Хүүхдийн нас, сэтгэхүй онцлог,тэдгээрийн сэтгэн бодох чадварт тохирсон хүмүүжил төлөвшил олгох контент бүтээж, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчинд түгээх | | 3.Түгээсэн контентын тоо, оноор | зохицуулах зөвлөлийн Ажлын алба | Иргэний нийгмийн байгууллага |
| 168. | 105.181.Гэр бүлийн үүрэг ролийг бэхжүүлж хүүхдийн насанд зохицсон чанартай боловсролын үйлчилгээгээр хангахад чиглэгдсэн дэмжлэг бүхий арга хэмжээ авч хүүхдийн эрхийн хамгааллыг сайжруулах (Иран) | 1.“Чанартай амьдрал-гэр бүлийн гишүүдийн оролцоо” хөтөлбөрийг хэрэгжүүлэх<br><br>2.Насан туршийн суралцахуйн төвүүдэд гэр бүлийн боловсрол олгох сургалт зохион байгуулах | Улсын төсөв | 1.Хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна<br><br>2.Гэр бүлийн сургалтад хамрагдсан хүний тоо, нас, хүйс, оноор | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар<br><br>Боловсролын яам<br><br>Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар |
| 169. | 105.184.Морины уралдаан зэрэг аюултай ажил эрхлэлтийн насны хамгийн бага хязгаарыг нэмэгдүүлж хүүхдийн хөдөлмөрийн байцаагч, нийгмийн ажилтныг зүй зохистой сургалтад хамруулах (Итали) | 1.Морины уралдаанч хүүхдийн насыг нэмэгдүүлэхэд чиглэсэн нөлөөллийн ажлыг үе шаттай зохион байгуулах<br><br>2.Хурдан морины уралдаанч хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах тухай сургалт, нөлөөллийн ажлыг үе шаттай зохион байгуулах, эцэг, эх асран хамгаалагчдын мэдлэг ойлголтыг сайжруулах | Улсын төсөв<br><br>Төсөл, хөтөлбөр | 1.Нөлөөллийн ажлын тоо, оролцсон хүний тоо, оноор<br><br>2.Сургалт, нөлөөллийн ажлын тоо, оролцсон хүний тоо, оноор | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам<br><br>Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар<br><br>Аймаг, нийслэлийн Засаг даргын |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Тамгын газар |
| 170. | 105.185.Олон улсын стандартын дагуу хүүхдийн шүүхийн үр дүнтэй, сайтар ажиллагаатай тогтолцоотой болох хүчин чармайлтаа үргэлжлүүлэх (Румын); | 1.Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн арга хэмжээг хэвийн явуулах нөхцөлөөр хангах<br><br>2.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг батлуулж, сурталчлан таниулах, сургалт зохион байгуулах | Улсын төсөв<br><br>Төсөл, хөтөлбөр | 1.Шүүх хэвийн арга хэмжээ явуулах эрх зүйн орчин тогтож, хүний нөөц, санхүү, техникийн нөхцөл хангагдсан байна<br><br>2.Сургалт, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулсан байна | Шүүхийн ерөнхий зөвлөл<br><br>Улсын дээд шүүх<br><br>Хууль зүй, дотоод хэргийн яам | Хууль зүйн үндэсний хүрээлэн<br><br>Сангийн яам<br><br>Засгийн газрын Хэрэг эрхлэх газар |
| Арван найм.Эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон ахмад настан зэрэг хүн амын эмзэг бүлгийн иргэдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах асуудал | | | | | | |
| 171. | 105.131.Залуучууд болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бизнес эрхлэлт, хөрөнгө оруулалт, тогтвортой амьжиргааг дэмжих чиглэлээр тэдний эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх санал, санаачилгыг үргэлжлүүлэн өргөжүүлэх (Этиоп) | 1.Залуучууд болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бизнес эрхлэлт, хөрөнгө оруулалт, тогтвортой амьжиргааг дэмжих зорилгоор санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх<br><br>2.Залуучууд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бизнес эрхлэлтэд зориулсан хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн санхүүжилтийн багц хэрэгжүүлэх ажлыг үе шаттайгаар төлөвлөн хэрэгжүүлэх<br><br>3.Бизнесийн анхан шатны сургалт, менторшип, зөвлөх үйлчилгээг зорилтот бүлэгт давтамжтай, хүртээмжтэй хэлбэрээр хэрэгжүүлэх | Улсын төсөв | 1.Дэмжлэг авсан иргэдийн тоо, бизнесийн 1 жилийн тогтвортой арга хэмжээний хувь, оноор<br><br>2.Сургалт, менторшипт хамрагдсан хүний тоо, оноор<br><br>3.Сургалтын дараа бизнес эхлүүлсэн/өргөжүүлсэн иргэдийн хувь | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам<br><br>Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам |
| 172. | 105.132.Эмэгтэйчүүдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг нь хамгаалах, нийгэм, | 1.Нийгмийн халамжийн тухай хуулийг шинэчилж асрахуйн | Улсын төсөв | 1.Хуулийн төслийг УИХ-д өргөн | Гэр бүл, хөдөлмөр, | Аймаг, нийслэлийн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | эдийн засгийн оролцоог нь нэмэгдүүлэх замаар эмэгтэйчүүдийг үргэлжлүүлэн дэмжих (Тажикистан) | үйлчилгээ, асрахуйн эдийн засгийг дэмжсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх<br><br>2.“Цалинтай эх, эцэг” нийгмийн хамгааллын бодлогыг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох<br><br>3.Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх үндэсний төлөвлөгөөг баталж, төрийн болон төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагын оролцоонд тулгуурлан хэрэгжүүлэх<br><br>4.Асрахуйн ажил үйлчилгээ эрхэлж буй эмэгтэйчүүдэд зориулсан сургалт, санхүүгийн дэмжлэг олгох үйлчилгээг албажуулж жил бүр зохион байгуулах | Төсөл, хөтөлбөр | мэдүүлсэн байна<br><br>2.Бодлого боловсронгуй болсон байна<br><br>3.Үндэсний төлөвлөгөө хэрэгжсэн байна<br><br>4.Сургалтад хамрагдсан эмэгтэйчүүдийн тоо болон санхүүгийн дэмжлэг авсан эмэгтэйчүүдийн тоо, оноор | нийгмийн хамгааллын яам | Засаг даргын Тамгын газар |
| 173. | 105.133.Нийгэм, гэр бүлийн хамтын хариуцлагыг дэмждэг асрахуйн цогц системээр дамжуулан ажил эрхлэх, эдийн засгийн боломжуудыг тэгш хүртэх баталгааг эмэгтэйчүүдэд олгосон төрийн бодлогыг бэхжүүлэх (Чили) | | | | | |
| 174. | 105.134.Эмэгтэйчүүдэд санхүүгийн эрх чөлөө олгодог эдийн засгийн боломжуудыг тэгш хүртэх илүү таатай орчныг бий болгосон бодлого, тогтолцоог дэмжих (Кипр) | | | | | |
| 175. | 105.135.Эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг дэмжсэн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх, ялангуяа эмэгтэй бизнес эрхлэгчид зээл хялбар авдаг байх, боломжийн үнэтэй асрах үйлчилгээг нэмэгдүүлэх, гэрийн цалингүй ажлын ачааллыг бууруулах замаар хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх (Португал) | | | | | |
| 176. | 105.187.Ахмад настан, эмэгтэйчүүд, хүүхэд болон нийгмийн бусад бүлгийн эрхийг хамгаалах бодлого, арга хэмжээ нэвтрүүлж эрх зүйн орчныг үргэлжлүүлэн сайжруулах (БНХАУ) | Гэр бүлд зөвлөгөө өгөх төвөөр дамжуулан эмэгтэйчүүдэд үйлчилгээ үзүүлэх | Улсын төсөв | Нийт эмэгтэйчүүдийн 15 хувь байна | Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам |
| 177. | 105.188.Хууль болон практикт хүүхэд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон ахмад настан зэрэг эмзэг бүлгийн хүмүүсийн эрхийг хамгаалах хүчин чармайлтаа үргэлжлүүлэх (ОХУ) | 1.Хөгжлийн бэрхшээлийн талаарх зөв ойлголт, мэдлэг олгоход чиглэсэн мэдээллийг олон нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар боловсруулж түгээх<br><br>2.Хүүхдийн эрх, хамгааллын салбар дундын төлөвлөгөө (2026-2030 он) батлуулж, хэрэгжүүлэх | Улсын төсөв | 1.Үр дүнг үнэлэх түүвэр судалгаа хийсэн байна<br><br>2.Батлагдсан баримт бичгийн тоо<br><br>3.Төсөл хэрэгжиж эхэлсэн байна | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам<br><br>Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар | Хууль зүй, дотоод хэргийн яам<br><br>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба |
| 178. | 105.194.Хүүхэд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон ахмад настан зэрэг эмзэг бүлгийнхний эрх, ашиг сонирхлыг хангах зорилтот арга хэмжээ авах (Узбекистан) | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 3.Ахмад настны урт хугацааны асаргааны чадавх бэхжүүлэх төсөл хэрэгжүүлэх<br><br>4.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх асаргааны үйлчилгээг шинээр бий болгох | | 4.Үйлчилгээ шинээр бий болсон байна | | Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс |
| 179. | 105.189.Ахмад настан нэр төртэй амьдрах, тэдний амьдралын чанарыг нь сайжруулахад дэмжлэг үзүүлэх, ялангуяа хүрэлцээтэй тэтгэвэр авах эрхийг нь хангах (Кипр) | Иргэдийн өндөр насны орлогын эх үүсвэрийг төрөлжүүлэх зорилгоор тэтгэврийн олон давхаргат тогтолцоонд шилжих арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх | Улсын төсөв | Хувийн нэмэлт тэтгэврийн эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна | Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газар | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам |
| 180. | 105.190.Ахмад настны асаргааг сайжруулах, ялангуяа хөдөө, орон нутгийн ахмад настны асаргааг сайжруулах (Доминикан) | 1.Ахмад настны асаргааны хувилбарт үйлчилгээг өдрөөр асрах үйлчилгээ, гэрээр асрах явуулын үйлчилгээ, түр, урт, байнгын хугацаагаар асрах үйлчилгээг аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэх, асрахуйн сургалтуудыг явуулах<br><br>2.Орон нутгийн ахмад настны асрамжийн газрын барилга байгууламжийг сайжруулах, шаардлагатай техник, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх | Улсын төсөв<br><br>Төсөл, хөтөлбөр | 1.Ахмад настанд чанартай хүртээмжтэй үйлчилгээ хүрсэн байна<br><br>2.Ахмад настны асрамжийн газруудад ахмадуудад ээлтэй орчин бүрдэж, үйлчилгээний чанар сайжирсан байна | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газар<br><br>Асрамжийн газрууд |
| 181. | 105.191Төрийн санхүүжилтийг нэмэгдүүлэх замаар бага насны хүүхэд болон ахмад настны асрах үйлчилгээг өргөжүүлэх (Эстони) | | | | | |
| 182. | 105.193.Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, эмэгтэйчүүд, хүүхэд болон ахмад настны хүртээмж болон нийгмийн харилцаанд оролцох оролцоог нэмэгдүүлэх бодлого, хөтөлбөрийг сайжруулах (Малайз) | Ахмад настны хөгжил, оролцоог нэмэгдүүлэх, эрүүл идэвхтэй насжилтыг дэмжих үйлчилгээг хэрэгжүүлэх | Улсын төсөв<br><br>Төсөл, хөтөлбөр | 2026-2030 онд үйлчилгээнд хамрагдсан ахмад настны тоо өссөн байна | Аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газар | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам<br><br>Иргэний нийгмийн байгууллага<br><br>Хувийн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэвшил |
| 183. | 105.196.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийг бэхжүүлэх, төвийн сургалтад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулах, нийгэмшүүлэхэд шаардлагатай хангалттай арга хэрэгсэл, санхүүжилтээр хангах (Венесуэл), (Боливи) | Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээг өргөжүүлж, арга хэмжээг оновчтой тогтоох | Улсын төсөв | Хөтөлбөрийн хүрээг өргөжүүлсэн байна | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар |
| 184. | 105.197.Цахим хүртээмжийн ялгааг арилгахын тулд дижитал технологийг хөгжлийн бэрхшээлтэй бүх хүмүүст хүртээмжтэй байлгах зохистой арга хэмжээ авах (БНСУ) | Мэдээллийн технологийг хөгжлийн бэрхшээлтэй бүх хүмүүст хүртээмжтэй байлгах зохистой арга хэмжээ авах | Улсын төсөв | Төрийн үйлчилгээ хөгжлийн бэрхшээлтэй бүх хүмүүст хүртээмжтэй болсон байна | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам | “И-Монгол академи” УТҮГ<br><br>Гадаадын иргэн, харьяатын газар |
| 185. | 105.198.Мэргэжлийн сургалт, хүртээмжтэй дэд бүтцийн тусламжтайгаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлт болон нийгмийн харилцаанд оролцох оролцоог үргэлжлүүлэн дэмжих (Азербайжан) | 1.Мэргэжлийн болон техникийн боловсролд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тэгш хамруулах орчныг бүрдүүлэх<br><br>2.Ажлын байрны дадлагажуулагчийг тасралтгүй бэлтгэж, тогтвортой ажиллуулахад чиглэсэн эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлж, хэрэгжилтийг хангах | Улсын төсөв<br><br>Төсөл, хөтөлбөр | 1.Мэргэжлийн болон техникийн боловсролд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо<br><br>2.Холбогдох хууль, журам батлагдсан байна | Боловсролын яам<br><br>Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам<br><br>Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар | Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар<br><br>Иргэний нийгмийн байгууллага |
| 186. | 105.199 Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг дэмжих, хангах арга хэмжээгээ үргэлжлүүлэх, түүний тулд тэдний нийгмийн харилцаанд бүрэн оролцуулах болон хүчирхийллээс хамгаалах тогтолцоо бий болгох (Япон) | 1.Хувийн туслах үйлчилгээг үндэсний хэмжээнд хөгжүүлэх<br><br>2.Хөгжлийн хоцрогдол, хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх олон улсын хөтөлбөрийг хэрэгжүүлэх | Улсын төсөв<br><br>Төсөл, хөтөлбөр | 1.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоо нэмэгдсэн байна<br><br>2.Олон улсад туршигдсан | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар<br><br>Эрүүл мэндийн яам |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | гурваас доошгүй хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна | | |
| 187. | 105.200.Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдийг дэмжих, мөн ядуурлын түвшнээс доогуур амьдралтай бүлгийн хүмүүсийг нийгмийн халамжийг үйлчилгээгээр дэмжих хүчин чармайлтаа үргэлжлүүлэх (Ирак) | Халамжаас-хөдөлмөр ядуурлыг бууруулах зорилтын хүрээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар 5000 өрхийн амьжиргааг дээшлүүлэх хөтөлбөрийг орон нутгийн удирдлагатай хамтран улсын хэмжээнд хэрэгжүүлэх | Улсын төсөв<br><br>Төсөл, хөтөлбөр | Амьжиргаа дээшилсэн өрхийн тоо, оноор | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газар |
| 188. | 105.201.Эмзэг бүлгийн иргэд, түүн дотор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах, сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүсийг Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын дагуу дэмжих үйл хэргээ бэхжүүлэх (Итали) | 1.Сэтгэцийн бэрхшээлтэй иргэдийг хөдөлмөрт бэлтгэх шилжилтийн хөтөлбөр хэрэгжүүлэх<br><br>2.Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тооцогдох сэтгэцийн эмгэгтэй иргэний асрамжийн төвд ажиллах сэтгэцийн эмч бэлтгэх | Улсын төсөв<br><br>Төсөл, хөтөлбөр | 1.Хөтөлбөр хэрэгжүүлсэн байна<br><br>2.Бэлдсэн сэтгэцийн эмчийн тоо, оноор | 1.Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам<br><br>2.Эрүүл мэндийн яам | Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар<br><br>Боловсролын яам |
| 189. | 105.202.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн туслалцаа үргэлжлүүлэн үзүүлэх (Казакстан) | Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг амьжиргааны түвшинтэй уялдуулан нэмэгдүүлж, үргэлжлүүлэн олгох | Улсын төсөв<br><br>Төсөл, хөтөлбөр | Тэтгэвэр, тэтгэмж нэгдсэн байна | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар |
| 190. | 105.203.Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй холбоотой үндэсний хууль тогтоомж, бодлогоо олон улсын хүний эрхийн стандартад нийцүүлж өөрчлөх (Бразил) | 1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг шинэчлэх<br><br>2.Монгол Улсын барилга, байгууламж, замын хүртээмжийн байдалд үнэлгээ хийж үнэлж, гэрчилгээжүүлж, цахим зураглал гаргах, нийтийн зориулалттай барилга, байгууламжид оюуны болон сэтгэцийн бэрхшээлтэй хүнд хялбар уншигдах болон зурган мэдээллийг нэвтрүүлэх | Улсын төсөв | 1.Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна<br><br>2-3.Хүртээмжтэй байгууламжийн мэдээлэлтэй болсон байна | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам<br><br>Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар | Иргэний нийгмийн байгууллага<br><br>Зам, тээврийн яам<br><br>Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам |
| 191. | 105.204.Үндэсний хууль тогтоомж, бодлогоо Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцод нийцүүлэх, үүний тулд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгардаг хууль зүйн болон орчны саад бэрхшээлийн үнэлгээ хийх, хөгжлийн бэрхшээлтэй хүн бие даан амьдрах, нийгмийн харилцаанд | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | бүрэн оролцохыг дэмжих (Хорват) | 3.Барилга байгууламжийн дэд бүтцийг сайжруулах чиглэлээр хүртээмжийн үнэлгээ зохион байгуулах | | | | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам |
| 192. | 105.205.Үндэсний хууль тогтоомжоо Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцод нийцүүлэх хүчин чармайлтаа үргэлжлүүлэх (Гүрж) | Дотоодын хууль тогтоомжийг конвенцод нийцэж байгаа эсэхэд үнэлгээ хийж, нийцүүлэх арга хэмжээ авах | Улсын төсөв | Үнэлгээг гүйцэтгэн, хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар |
| 193. | 105.206.Хүртээмжтэй, саадгүй орчны тухай хуулийг Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагын оролцоотойгоор сайжруулах (Доминикан) | Хүртээмжтэй, саадгүй орчны тухай хуулийн төслийг боловсруулах | Улсын төсөв | Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар<br><br>Иргэний нийгмийн байгууллага |
| 194. | 105.207.Дохионы хэлний тухай хууль болон түүнийг хэрэгжүүлэх үндэсний төлөвлөгөөг сайжруулах (Доминикан) | Дохионы хэлний тухай хуулийн төслийг боловсруулах | Улсын төсөв | Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар<br><br>Иргэний нийгмийн байгууллага |

---o0o---

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2026 оны 03 дугаар сарын 11-ний өдөр | Дугаар 77 | Улаанбаатар хот

**Жагсаалт батлах тухай**

Биеийн тамир, спортын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсад 2026 онд зохион байгуулах олон улс, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээний жагсаалт”-ыг хавсралт ёсоор батлахсугай.

2.Энэ тогтоолын хавсралтад заасан тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах зардлыг 2026 оны батлагдсан төсвийн багцаас санхүүжүүлж, төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Ундрам, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар нарт даалгасугай.

3.Тэмцээний бэлтгэл ажлыг сайтар хангаж, өндөр түвшинд зохион байгуулахыг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Ундрам, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД** **Г.ЗАНДАНШАТАР**

**СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН САЙД** **Ч.УНДРАМ**

Засгийн газрын 2026 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 77 дугаар тогтоолын хавсралт

## МОНГОЛ УЛСАД 2026 ОНД ЗОХИОН БАЙГУУЛАХ ОЛОН УЛС, ТИВ, ДЭЛХИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ ЖАГСААЛТ

| № | Тэмцээний нэр |
|---|---|
| 1. | Дэлхийн их дуулга жүдо бөхийн “Улаанбаатар 2026” тэмцээн |
| 2. | Боксын насанд хүрэгчдийн Ази тивийн аварга шалгаруулах тэмцээн |
| 3. | Таеквондогийн насанд хүрэгчдийн Ази тивийн аварга шалгаруулах XXVII тэмцээн (пүмсэ болон пара спортын ангилалтай) |
| 4. | Олон улсын чөлөөт бөхийн “Улаанбаатар опен” тэмцээн |
| 5. | Шатрын насанд хүрэгчдийн Ази тивийн аварга шалгаруулах тэмцээн |
| 6. | Дэлхийн гранпри сагсан бөмбөгийн 3x3 эмэгтэйчүүдийн цуврал тэмцээн |
| 7. | Волейболын эрэгтэйчүүдийн Азийн зүүн бүсийн аварга шалгаруулах тэмцээн |
| 8. | “Контр-Страйк (CS)” и-спортын олон улсын тэмцээн |

---o0o---

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 2026 оны 03 дугаар сарын 11-ний өдөр | Дугаар 79 | Улаанбаатар хот |

**Журам батлах тухай**

Малчны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.7 дахь заалт, 4.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Гамшигт болон аюулт үзэгдлийн улмаас ажил үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан малчны ар гэрт буцалтгүй тусламж олгох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Журмыг хэрэгжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд Х.Ганхуяг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд М.Бадамсүрэн нарт тус тус даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД** **Г.ЗАНДАНШАТАР**

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД** **М.БАДАМСҮРЭН**

Засгийн газрын 2026 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 79 дүгээр тогтоолын хавсралт

**ГАМШИГТ БОЛОН АЮУЛТ ҮЗЭГДЛИЙН УЛМААС АЖИЛ ҮҮРГЭЭ ГҮЙЦЭТГЭЖ ЯВААД АМЬ НАСАА АЛДСАН МАЛЧНЫ АР ГЭРТ БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖ ОЛГОХ ЖУРАМ**

**Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Энэ журмын зорилго нь гамшигт болон аюулт үзэгдлийн улмаас ажил үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан малчин, түүний туслах малчны ар гэрт нэг удаагийн буцалтгүй тусламж олгохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2.Энэ журамд хэрэглэсэн нэр томьёог доор дурдсанаар ойлгоно:

1.2.1.“малчин” гэж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.9-д заасан мал аж ахуй эрхэлж үндсэн орлогоо олдог иргэнийг;

1.2.2.“туслах малчин” гэж Хөдөлмөрийн тухай хуулийн 71.2-т заасан үндсэн малчны дэргэд амьдарч, түүний удирдлага, хяналтын доор мал маллах, мал аж ахуйтай холбоотой бусад ажил эрхэлж цалин хөлс авахаар харилцан тохиролцон ажиллаж байгаа хүнийг;

1.2.3.“ар гэр” гэж Гэр бүлийн тухай хуулийн 3.1.4-т заасан гэр бүлийн үндсэн гишүүдийг;

1.2.4.“аюулт үзэгдэл” гэж Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.2-т заасан хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, аянга, газар хөдлөлт, нуранги, хөрсний гулгалт үүсэх, гал түймэр, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин гарах, цар тахал, хортон шавж, мэрэгч тархах зэргийг;

1.2.5.“гамшиг” гэж Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.1-д заасан аюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд улс болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн дотоод нөөц, боломжоос давсан хохирол учрахыг.

## Хоёр.Буцалтгүй тусламж олгох нөхцөл, хэмжээ, бүрдүүлэх материал

2.1.Малчин, туслах малчин нь гамшигт болон аюулт үзэгдлийн үед ажил үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан болохыг нотолсон холбогдох мэргэжлийн байгууллагын акт, дүгнэлт, нотлох баримтад үндэслэн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 48 сараар тооцож, түүнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламжийг ар гэрт нь олгоно.

2.2.Энэ журмын 2.1-д заасан нөхцөл байдал тогтоогдсоноос хойш 30 хоногийн дотор буцалтгүй тусламж олгоход шаардагдах баримт бичгийг харьяалах сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар, түүний холбогдох албан тушаалтан хариуцан дараах баримтыг малчин, туслах малчны ар гэр болон мэргэжлийн байгууллагаас авч аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ:

2.2.1.нэг удаагийн буцалтгүй тусламж хүссэн өргөдөл;

2.2.2.гэрлэсэн болон гэрлээгүйг нотлох баримтын хуулбар (Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем “e-mongolia”-аас авсан байж болно);

2.2.3.нас барсны гэрчилгээ;

2.2.4.туслах малчны хувьд энэ журмын 2.2.1-2.2.3-т заасан баримт бичгийг мөн адил бүрдүүлэх бөгөөд Хөдөлмөрийн тухай хуулийн 71.1-д заасны дагуу малчин өрхтэй байгуулсан гэрээний хуулбар;

2.2.5.гамшигт болон аюулт үзэгдэл болсон тухай харьяалах орон нутгийн цаг уур, орчны шинжилгээний болон онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тодорхойлолт;

2.2.6.нас барсан шалтгаан нь гамшигт болон аюулт үзэгдэлтэй холбоотой болохыг тогтоосон холбогдох байгууллагын дүгнэлт (харьяалах орон нутгийн цагдаагийн байгууллагын тодорхойлолт, эмнэлгийн магадалгаа, шүүх эмнэлгийн дүгнэлт);

2.2.7.малын үндэсний бүртгэл мэдээллийн сан (livestock.mofa.gov.mn)-д малчин өрхийн гишүүнээр бүртгэгдсэн талаарх тодорхойлолт (туслах малчинд хамаарахгүй).

**Гурав.Санхүүжүүлэх эх үүсвэр**

3.1.Энэ журмын 2.1-д заасан зардлыг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32.1.3, 51.2, 51.4-т заасны дагуу аймаг, нийслэлийн нөөц хөрөнгөөс гаргана.

3.2.Тухайн шатны Засаг даргын нөөц хөрөнгөөс давсан, нөөц хүрэлцэхгүй тохиолдолд нэмэлт санхүүжилтийн хүсэлтийг Улсын онцгой комисст хүргүүлэх бөгөөд Улсын онцгой комисс материалыг хууль тогтоомжид нийцүүлэн хянаж, Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлэх арга хэмжээ авна.

**Дөрөв.Бусад**

4.1.Гамшигт болон аюулт үзэгдлийн улмаас амь насаа алдсан малчин, туслах малчны ар гэрт олгосон буцалтгүй тусламжийн санхүүжилт, гүйцэтгэлийн мэдээ, тайланг Төсвийн тухай хуулийн дагуу тайлагнана.

4.2.Буцалтгүй тусламж олгох үйл ажиллагаанд хуурамч баримт бичиг бүрдүүлсэн бол буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---о0о---

**Хаяг:**
“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeelel@parliament.mn
**Утас:** 262420
Хэвлэлийн хуудас: 5
**Индекс: 200003**